

1. Танилцуулга

Төв банк ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд инфляцийн талаарх олон нийтийн хүлээлтийг тодорхойлон бодлогын шийдвэр гаргахдаа ашиглах нь чухал ач холбогдолтой. Энэхүү түүвэр судалгааны зорилго нь инфляцийн хүлээлтийн талаарх иргэд, аж ахуйн нэгж болон шинжээчдийн дунд түүвэрчилсэн санал асуулга явуулж, тэдгээрийн хүлээлтийг тодорхойлоход оршино. Судалгааны үр дүнг цаашид мөнгөний бодлогын загварчлал болон бусад судалгаанд ашиглах боломжтой болох юм.

Монголбанкнаас анх удаа инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг хэрэглэгчдийн дунд 2008 оны 12 дугаар сард, аж ахуйн нэгж, шинжээчдийн дунд 2009 оны 3 дугаар сард явуулсан бөгөөд 2009 оны 9 дүгээр сард МЕК ХХК-тай хамтран хэрэглэгчид, аж ахуйн нэгж, шинжээчдийн дунд зэрэг явууллаа. Эхний судалгаанд инфляцийн хүлээлтийн санал асуулгын түүврийн хүрээг Улаанбаатар хотын төвийн дүүргүүдээр хязгаарлаж байсан бол энэ удаагийн судалгаанд алслагдсан дүүргүүд болох Налайх, Багануур дүүргийн иргэдийг оролцуулан түүврийн хэмжээг өргөтгөв. Мөн иргэдэд илүү ойлгомжтой болгох үүднээс санал асуулгын үг хэллэгийн сонголтыг өөрчилж, асуулгын маягтыг шинэчлэн боловсруулсан.

Инфляцийн хүлээлтийг тооцохдоо ирээдүйн үнийн түвшний өөрчлөлтийн талаарх чанарын хариултыг инфляцийн тоон утганд хөрвүүлж тооцдог өргөтгөсөн Carlson ба Parkin (1975)-ны магадлалын аргыг ашиглалаа. 2008 оны 12 дугаар сард явуулсан хэрэглэгчдийн түүвэр судалгааны үр дүнд хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт 20.4 хувь, 2009 оны 3 дугаар сард явуулсан аж ахуйн нэгж болон шинжээчдийн санал асуулгын үр дүнд инфляцийн хүлээлт харгалзан 14.9, 19.7 хувь гарч байсан. Энэхүү өндөр хүлээлт нь тухайн үеийн санхүү, эдийн засгийн хямрал, инфляцийн өндөр түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааралтай байж болох юм.

Энэ удаагийн инфляцийн хүлээлтийн судалгаа нь Улаанбаатар хотод дефляцитай үед явагдсанаараа онцлог байлаа. Учир нь дефляцитай үед инфляцийн хүлээлтийг хэрхэн тооцоолох асуудал нь маргаантай асуудал юм. Иймээс Монголбанкинд ирж зөвлөгөө өгч байсан Польшийн Төв Банкны мэргэжилтэн Tomasz Łyziak¹ –аас зөвлөгөө авахаар МБХ-ийн эдийн засагч Д.Батнямаар дамжуулан электрон шуудан илгээж зөвлөгөө авлаа. Ингээд хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийг тооцоолохдоо бид Т.Łyziak –ийн зөвлөсний дагуу өргөтгөсөн магадлалын аргаар, мөн үнийн хэлбэлзэл ихтэй бараануудын үнийн индексийг² хасаж тооцсон цэвэр инфляциар тус тус тооцооллоо.

¹ National Bank of Poland, Economic Institute, Bureau of Economic Research

² Хүнсний бүлэг, шатахууны үнийн индексийг хассан

Уг судалгааны ажил нь дараах бүтэцтэй байна. Эхний хэсэгт инфляцийн хүлээлтийн талаарх ерөнхий танилцуулга, хоёрдугаар хэсэгт инфляцийн хүлээлтийг тооцох загварыг танилцуулна. Гуравдугаар хэсэгт хэрэглэгчдийн санал асуулын дүн, дөрөвдүгээр хэсэгт аж ахуй нэгжийн санал асуулгын дүн, тавдугаар хэсэгт шинжээчдийн санал асуулгын дүнг танилцуулна. Эцсийн буюу зургадугаар хэсэгт нэгтгэн дүгнэнэ.

2. Өргөтгөсөн Carlson-Parkin-ны магадлалын арга³

Инфляцийн хүлээлтийг тооцохдоо ирээдүйн үнийн түвшний өөрчлөлтийн талаарх иргэдийн түүвэр суудалгааг ашигладаг бөгөөд судалгааны асуулгыг ирээдүйд хүлээгдэж буй инфляцийн түвшинг одоогийн инфляцийн түвшинтэй харьцуулсан чанарын хариултаар авдаг.

Магадлалын аргыг анх Theil (1952) боловсруулсан бөгөөд Carlson ба Parkin (1975), Taylor (1988), Seitz (1988) нар өөрсдийн судалгаандаа ашигласан байдаг. Инфляцийн хүлээлтийг тооцох хувьсагччууд нь үнийн түвшин “өснө”, “өөрчлөгдөхгүй” эсвэл “буурна” гэсэн чанарын хүлээгдэж буй хариултаар илэрхийлэгдэнэ. Чанарын хариулт нь тоогоор илэрхийлэгдэхгүй, тухайн хувьсагчийн өөрчлөлтийн ерөнхий хандлагыг харуулах бөгөөд түүнийг магадлалын функц ашиглан инфляцийн тоон утганд хөрвүүлж хүлээлтийг тооцож гаргадаг. Энэ арга нь дараах 2 үндсэн таамаглал дээр тулгуурладаг. Нэгдүгээрт, хувь хүн бүр хүлээгдэж буй үнийн өөрчлөлтийн тархалтын функцтэй байх бөгөөд уг функц нь цаг хугацаа болон иргэдийн хувьд өөр өөр байж болно. Хоёрдугаарт, иргэдийн хүлээгдэж буй үнийн түвшин нь өөрчлөгдөхгүй гэж үзвэл хүлээгдэж буй үнийн өөрчлөлт нь тэг төвтэй тодорхой интервалын хооронд оршино гэж таамагладаг. Энэ интервалыг “мэдрэмжийн интервал” буюу “өөрчлөлтгүй интервал” гэнэ.

Өргөтгөсөн Carlson ба Parkin (1975) нарын магадлалын аргад хариултын хувилбаруудыг нэмсэн бөгөөд “түүврийн тоо хангалттай их бол хүлээгдэж буй үнийн түвшний өөрчлөлт нь нийт хүн амын хувьд нормаль(хэвийн) тархалттай байна” гэсэн таамаглалыг тавьсан. Судалгаанд оролцогчид ирэх 12 сарын үнийг одоогийн түвшинтэй харьцуулахад “илүү хурдан өснө”, “ ижил хувиар өснө”, “ илүү удаан өснө”, “хэвэндээ байна”, “буурна”, “мэдэхгүй” гэсэн хувилбаруудаас сонголтоо хийнэ. Үүнд, “хэвэндээ байна” эсвэл “ижил хувиар өснө” гэсэн хоёр хариулт нь тоогоор илэрхийлэгддэг. Хэрэв “хэвэндээ байна” гэж үзвэл ирэх 12 сарын турш үнийн өөрчлөлт нь тэгтэй тэнцэнэ гэсэн үг бөгөөд хүлээгдэж буй инфляцийн түвшин нь тэг төвтэй, $(-t; +t)$ мэдрэмжийн интервалын хооронд оршино. Харин “ижил хувиар өснө” гэж үзвэл хүлээгдэж буй инфляцийн түвшин нь тухайн үеийн инфляцийн түвшинд төвтэй, $(\pi_0 - s ; \pi_0 + s)$ интервалын хооронд байна.

Тооцоололтыг хийхийн тулд эхлээд хариултын хувилбар тус бүрийг судалгаанд оролцогчдын хэдэн хувь нь сонгосныг тооцож гаргана. Ингэхдээ мэдэхгүй гэсэн хариултын хувийг бусад хувилбарт тэнцүү хувааж тохиргоо хийдэг.

a - Өнгөрсөн 12 сарынхаас илүү их хурдацтайгаар өснө гэсэн хариултын хувь (a)

b - Өнгөрсөн 12 сарынхтай бараг ижил хувиар өснө (б)

³ Łyziak, Tomasz., Stanisławska, Ewa. 2006, “Consumer inflation expectations. Survey questions and quantification methods – the case of Poland”, *NBP Papers* No. 37, National Bank of Poland.


с - Өнгөрсөн 12 сарынхаас бага өснө (в)

d - Үнэ хэвэндээ байна (г)

e - Үнэ буурна (д)

Инфляцийн хүлээлтийн чанарын хариултыг тоо болгож хөрвүүлэхийн тулд дараах тэгшитгэлүүдийг ашигладаг. (График дүрслэлийг зураг 1-д харуулав)

Зураг 1. Өргөтгөсөн Carlson-Parkin-ны магадлалын арга



$$a = P(\pi_{+12}^e > \pi_0 + s) = 1 - F_c(\pi_0 + s)$$

$$b = P(\pi_0 - s < \pi_{+12}^e < \pi_0 + s) = F_c(\pi_0 + s) - F_c(\pi_0 - s)$$

$$c = P(t < \pi_{+12}^e < \pi_0 - s) = F_c(\pi_0 - s) - F_c(t)$$

$$d = P(-t < \pi_{+12}^e < t) = F_c(t) - F_c(-t)$$

$$e = P(\pi_{+12}^e < -t) = F_c(-t)$$

Үүнд: F_c – хүлээгдэж буй инфляцийн тархалтын функц (өссөн)

π_{+12}^e - ирэх 12 сарын хүлээгдэж буй инфляцийн түвшин

π_0 - тухайн үеийн инфляцийн түвшин

s, t – мэдрэмжийн интервалын урт

Тархалтын параметрууд болон интервалын урт нь эндоген хувьсагчид байх бөгөөд дараах томъёог ашиглан хүлээгдэж буй инфляцийн тархалтын функцээс инфляцийн хүлээлтийн дундаж болон бусад параметруудийг олж болно:

$$F_c(k) = Nz \left(\frac{k-m}{\sigma} \right) \quad N(0,1)$$

$$m = \frac{\pi_0 \cdot (C + D)}{C + D - (A + B)}$$

$$\sigma = \frac{-2 \cdot \pi_0}{C + D - (A + B)}$$

$$s = \frac{\pi_0 \cdot (B - A)}{D + C - (A + B)}$$

$$t = \frac{\pi_0 \cdot (D - C)}{D + C - (A + B)}$$

Үүнд:

$$A = Nz^{-1}(1-a); \quad B = Nz^{-1}(1-a-b); \quad C = Nz^{-1}(1-a-b-c); \quad D = Nz^{-1}(e).$$

m - хүлээгдэж буй инфляцийн дундаж

σ - стандарт хазайлт

Эндээс хүлээгдэж буй инфляцийн дунджийг m коэффициентийг олох томъёогоор тооцох бөгөөд энэ нь асуулгын хариултын тархалт болон одоогийн инфляцийн түвшнээс хамаарч байна.

3. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүн

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2009 оны 9 дүгээр сарын 1 өдрөөс 10 өдрийн хооронд явууллаа. Нийт 1000 иргэдээс санал асуулгыг авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 22 хувь нь Баянзүрх, 20.7 хувь нь Сонгино-Хайрхан, 16.6 хувь нь Баянгол, 12.5 хувь нь Чингэлтэй, 11 хувь нь Сүхбаатар, 10.8 хувь нь Хан-Уул, 3.3 хувь нь Багануур, 3.1 хувь нь Налайх дүүргийн иргэд байлаа.

3.1. Хэрэглэгчдийн мэдээлэл

Хүснэгт 1. Хэрэглэгчдийн мэдээлэл

		Хариулсан хүний тоо	Нийт асуулгад оролцогчдоод эзлэх хувь
Хүйс	Эрэгтэй	368	36.8%
	Эмэгтэй	632	63.2%
	Нийт	1000	100.0%
Нас	18-25	212	21.2%
	26-35	268	26.8%
	36-45	251	25.1%
	46-55	170	17.0%
	56-аас дээш	99	9.9%
	Нийт	1000	100.0%
	Боловсрол	Дээд	496
Бүрэн дунд		402	40.2%
Бүрэн бус дунд		83	8.3%
Бага		11	1.1%
Боловсролгүй		8	0.8%
Нийт		1000	100.0%
Ам бүлийн тоо	1	23	2.3%
	2-3	369	36.9%
	4-5	467	46.7%
	5-аас дээш	141	14.1%
	Нийт	1000	100.0%
Ажил эрхлэлт	Төрийн алба	162	16.2%
	Хувиараа	262	26.2%
	Хувийн байгууллага	228	22.8%
	Төрийн бус байгууллага	46	4.6%
	Цагийн ажил	24	2.4%
	Ажилгүй	243	24.3%
	Тэтгэвэрт	27	2.7%
	Хариулаагүй	8	0.8%
Нийт	1000	100.0%	
Өрхийн орлого	100 мянгаас бага	95	9.5%
	101-200 мянга	216	21.6%
	201-300 мянга	266	26.6%
	301-400 мянга	199	19.9%
	401-500 мянга	98	9.8%
	500 мянгаас дээш	99	9.9%

Мэдэхгүй	10	1.0%
Хариулаагүй	17	1.7%
Нийт	1000	100.0%

Нийт судалгаанд оролцогчдын 63.2 хувь нь эмэгтэй хэрэглэгчид байснаас харвал эмэгтэйчүүд илүү идэвхтэй хамрагдсан байна. Насны бүтцээс харвал судалгаанд оролцогчдын 51.9 хувь нь буюу талаас илүү хувь нь 26-45 насны иргэд байгаа бөгөөд энэ насны иргэд нь худалдан авах шийдвэрээ бие дааж гаргах чадвартай, үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд байна. Боловсролын түвшинг харахад 89.6 хувь нь бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд байлаа. Харин ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 83.6 хувь нь 2-5 ам бүлтэй иргэд байлаа. Ажил эрхлэлтийн байдлыг харвал 50.0 хувь орчим нь хувийн салбарт ажилладаг, 24.3 хувь нь ажилгүй иргэд байгаа нь үнийн өсөлтийг илүү мэдрэх боломжтой иргэд байна. Харин судалгаанд оролцогчдын өрхийн орлогыг харвал 68.1 хувь нь 100-400 мянган төгрөгийн орлоготой иргэд байна. Тэр дундаа 48.2 хувь нь 100-300 мянган төгрөгийн өрхийн орлоготой иргэд байгаа нь үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд байлаа. Тус санал асуулгад эмэгтэй, 26-45 насны, бүрэн дунд болон дээд боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, 100-400 мянган төгрөгийн орлоготой, 2-5 ам бүлтэй иргэд түлхүү оролцжээ.

3.2. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгад хэрэглэгчдээс тодорхой тоон хариултыг авахгүй бөгөөд тэдний ирээдүйн инфляцийн таамаглалыг одоогийн инфляцийн түвшинтэй харьцуулан чанарын хариултаар авдаг. Гол асуултын дүнг хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 2. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын гол асуултын дүн

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	2009 оны 9 сар		2008 оны 12 сар	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	253	25.3%	242	23.2%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	322	32.2%	256	24.6%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	166	16.6%	202	19.4%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	41	4.1%	100	9.6%
5. Үнэ буурна	14	1.4%	48	4.6%
6. Мэдэхгүй	204	20.4%	193	18.6%
Нийт	1000	100%	1041	100%

Энэ удаагийн судалгаа нь Улаанбаатар хотод дефляцитай үед явагдсан. Харин чанарын хариултыг тоон үзүүлэлт рүү шилжүүлэх магадлалын аргачлалаар дефляцитай үед хэрхэн

тооцоолох талаар онолын аргачлал болон улс орнуудын практик жишээ байхгүй гэж хэлж болохоор байна. Иймээс бид инфляцийн хүлээлтийг 2 янзаар тооцоолсон.

Нэгдүгээрт, Монголбанкинд ирж зөвлөгөө өгч байсан Польшийн Төв Банкны мэргэжилтэн Tomasz Łyziak –аас зөвлөгөө авахаар МБХ-ийн эдийн засагч Д.Батнямаар дамжуулан электрон шуудан илгээж зөвлөгөө авсан. Түүний зөвлөгөөнд дефляцитай үед инфляцийн хүлээлтийг тооцоолох нь маргаантай асуудлуудын нэг гэдгийг дурьдаад, хэрэв дефляци нь түр зуурын үзэгдэл бол өргөтгөсөн Carlson-Parkin –ны аргачлалын хүлээлтийг тооцоолох тооцооллыг⁴ бага зэрэг өөрчилснөөр тооцоолж болох юм гэжээ. Энэ тооцооллын⁵ санаа нь дефляцийн түвшинг эерэг буюу инфляцийн түвшин болгож тооцоолоод, эргээд дефляцийн түвшин рүү шилжүүлэн тооцоолох явдал байсан юм. Ингээд Т.Łyziak –ийн зөвлөсөн тооцооллын дагуу хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт **-1.84** хувь байна.

Хоёрдугаарт, 2009 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод дефляцитай гарсан нь 2008 оны мөн үетэй харьцуулахад голчлон шатахууны үнэ болон хүнсний бараа бүтээгдэхүүний бүлгийн үнэ буурсантай холбоотой бөгөөд түүн дотроо мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо мөн талх, гурилан бүтээгдэхүүний үнэ буурсан нь ихээр нөлөөлжээ. Хүнсний бараа бүтээгдэхүүний бүлэг болон шатахууны үнийн индексийг хасаж тооцоолсон Улаанбаатар хотын цэвэр инфляцийн түвшин жилийн 2.5⁶ хувь байгаа бөгөөд цэвэр инфляцийн түвшингээр тооцоолсон хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт **2.59** хувь байна.

Эхний санал асуулгын дүнд хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт өндөр гарсан нь санхүү, эдийн засгийн хямрал, инфляцийн өндөр түвшин, хэрэглэгчдийн банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл сул, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өсөлт гэх зэрэг тухайн үеийн эдийн засаг, банк санхүүгийн нөхцөл байдал муудсантай холбоотой юм.

Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэмжээ болон дэлхийн эдийн засгийн орчны нөлөөллийн дүнд инфляцийн түвшин 2009 оны эхний 9 сард огцом буурч эхэлсэн бөгөөд улмаар хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийг огцом бууруулахад хүргэсэн байна. ҮСХ-ны мэдээгээр 2009 оны 9 дүгээр сарын эцэст улсын хэрэглээний ХҮИ-ийн түвшин жилийн 0.02 хувь болж, Улаанбаатар хотынх -1.9 хувь болж тус тус буурсан байна. Улаанбаатар хотын инфляцийн түвшин буурахад тээврийн үйлчилгээний үнэ 6.8 хувь, орон сууц, түлш, цахилгааны үнэ 7.2 хувь, хүнсний барааны бүлгийн үнэ 7.8 хувиар тус тус буурсан нь голчлон нөлөөлсөн бөгөөд эдгээрээс шатахууны үнэ 23.7 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 20.9 хувиар, хүнсний ногооны үнэ 4.1 хувиар буурсан байна.

$$^4 \pi^e = \pi_0 \cdot \frac{(C+D)-(A+B)}{C+D-(A+B)}$$

$$^5 \pi^e = \pi_0 + (2 - \pi_0) \cdot \frac{(C+D)-(A+B)}{C+D-(A+B)-(2-\pi_0)}$$

⁶ Монголбанкны мөнгөний бодлогын загварт хэрэглэгддэг цэвэр инфляцийн түвшин

Монголбанкнаас хямралын эхэн үеээс авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлогын үр дүнд 2008 оны 8 дугаар сард 33.7 хувьд хүрээд байсан инфляцийн түвшин буурч, цаашид эдийн засаг тогтворжих хандлагатай байна. Монголбанк 2009 оны 5, 6 дугаар саруудад бодлогын хүүгээ тус бүр 1.25 нэгжээр бууруулж 11.5 хувьд хүргэсэн бөгөөд, хамгийн сүүлд 10 сард 1.5 нэгжээр буулгаж 10.0 хувь болгосон нь мөнгөний бодлогоо зөөллөж буйтай холбоотой юм.

Харин төсвийн бодлогын хувьд сүүлийн жилүүдэд хэт тэлэх бодлогыг баримталж байсны улмаас хямрал нүүрлэх үед засгийн газраас зардлаа өсгөж эдийн засгийг дэмжихэд хүнд болж ирсэн юм. Сүүлийн үед иргэдийн дунд Оюу-Толгойн орд газрыг ашиглалтанд оруулахтай холбоотойгоор орж ирсэн 100 сая долларын зээлийг иргэдэд тараахаар яригдаж буй, мөн иргэн бүрт 1.0 сая, 1.5 сая төгрөг өгөх улс төрийн амлалтуудаас үүдэж инфляцийн хүлээлт өсөх хандлага бий болж болзошгүй юм. Энэ нь эргээд үнэ өсөх дарамтыг бий болгож болно.

Хямралаас үүдэн дэлхийн зах зээл дээрх гол түүхий эдийн үнэ ихээр буугаад байсан боловч эрэлт нэмэгдсэнээс шалтгаалан өсөх хандлагатай байна. Тухайлбал 2009 оны 2 сарын 27-нд нэг баррель нь 36 ам.долларт хүрээд байсан түүхийн нефтийн үнэ⁷ 9 сард 70-80 ам.долларын хооронд хэлбэлзсэн байна. Мөн ихэнх металын үнэ 2009 оны 2 дугаар улиралд ихээр буураад байсан боловч металын үнийн индекс⁸ 2009 оны 7 дугаар сарын эцэст оны эхнээс 60 хувиар өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүний индекс 2009 оны 7 сарын эцэст оны эхнээс 15.0 хувиар өссөн байна.

ОУВС-гийн тайлангаас⁹ харвал санхүүгийн системийн эрсдэл, тодорхой бус байдлыг бууруулах, эрэлтийг дэмжих өргөн хүрээтэй бодлогуудыг явуулсны үндсэн дээр дэлхийн эдийн засгийн уналт зогсож, 2009 оны эцэст эерэг гарах төлөвтэй байна. Энэ нь санхүү, эдийн засгийн хямралын нөлөө багасч байгаагийн дохио боловч санхүүгийн систем муу хэвээр, нийгмийн бодлогын үр дүн бага, ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байгаа гэдгийг онцолсон байна. Макро эдийн засгийн бодлого хөл дээрээ бат зогсох хүртэл санхүүгийн системийг тогтворжуулах бодлогоо үргэлжлүүлэн баримтлах нь зүйтэй гэжээ. ОУВС-гийн таамаглалаар Монголд инфляци 2009 оны эцэст 8.5 хувь, 2010 оны эцэст 6.0 хувь байна гэж таамагласан байна. Харин АХБ (Азийн хөгжлийн банк) –ны таамаглалаар 2009 оны эцэст 10.0 хувь, 2010 оны эцэст 7.9 хувь байна гэж таамаглажээ. Ийнхүү дэлхийн эдийн засаг сэргэх төлөв байдалтай байгаа нь хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийг бууруулах нэг гол шалтгаан нь болж байна.

⁷ IMF. Average Petroleum Spot Price (APSP).

⁸ IMF. Metal price index.

⁹ IMF. 2009 October, "World Economic Outlook - Sustaining the Recovery".

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь хүйс, боловсрол, ажил эрхлэлт, нас болон өрхийн орлогоос хамаарах магадлалтай юм. Тиймээс эдгээр хамаарлыг тодруулах үүднээс хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн гол асуултын дүнг ангилан авч үзлээ.

3.2.1. Хүйсийн ангилал

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь хүйсээс хамааран ялгавартай байж болох тул гол асуултын дүнг хүйсээр ангилж үзлээ. Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээллээр 2008 онд Монгол улсад 2 сая 683.5 мянган хүн амын 1 сая 309.9 мянга буюу 48.8 хувь нь эрэгтэй, 1 сая 373.6 мянга буюу 51.2 хувь нь эмэгтэй байна. Харин нийт санал асуулгад оролцогчдын 63.2 хувь нь эмэгтэй, 36.8 хувь нь эрэгтэй иргэд байснаас харахад эмэгтэйчүүд илүү идэвхтэй оролцсон байна.

Хүснэгт 3. Хүйсийн ангиллаар (хувь)

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Хүйс	
	Эрэгтэй	Эмэгтэй
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	22.6%	26.9%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	30.7%	33.1%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	18.2%	15.7%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	6.3%	2.8%
5. Үнэ буурна	2.2%	0.9%
6. Мэдэхгүй	20.1%	20.6%
Нийт	100%	100%

2-р хариултыг эрэгтэйчүүдийн 30.7 хувь, эмэгтэйчүүдийн 33.1 хувь нь, 1-р хариултыг эрэгтэйчүүдийн 22.6 хувь, эмэгтэйчүүдийн 26.9 хувь нь тус тус сонгосон байна. Мөн 3-р хариултыг эрэгтэйчүүдийн 18.2 хувь нь, эмэгтэйчүүдийн 15.7 хувь нь сонгожээ. Харин 4-р хариулт болох “үнэ өөрчлөгдөхгүй” гэсэн хариултанд эрэгтэйчүүдийн 6.3 хувь нь хариулсан байхад эмэгтэйчүүдийн 2.8 хувь нь энэ хариултыг сонгожээ. Мөн “үнэ буурна” гэж эрэгтэй хэрэглэгчдийн 2.2 хувь нь, эмэгтэй хэрэглэгчдийн 0.9 хувь нь үзэж байна. 6-р хариултын хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Нийт судалгаанд оролцогчдын ихэнх хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд хариултаудын хувьд эрс ялгаа төдийлөн ажиглагдсангүй. Хамгийн их зөрүүтэй нь 1-р хариулт бөгөөд 4.3 нэгжээр ялгаатай хариулжээ.

3.2.2. Насны бүлэг

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь насны бүлгээс хамааралтай байх магадлалтай. Нийт санал асуулгад оролцогчдын 26.8 хувь нь 26-35 насны, 25.1 хувь нь 36-45, 21.2 хувь нь 18-25, 17 хувь нь 46-55 ба үлдсэн 9.9 хувь нь 56-аас дээш насны иргэд хамрагдсан байна. Эндээс харахад 26-45 насны иргэд судалгаанд идэвхтэй хамрагдсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 51.9 хувийг эзэлж байна. ҮСХ-ны мэдээгээр 2008 оны эцэст

Монгол улсын нийт суурин хүн амын 10.5 хувь нь 20-24 насны, 31.3 хувь нь 25-44 насны, 10 хувь нь 45-54 насны, 8.8 хувь нь 55-аас дээш насны иргэд байсан байна.

Хүснэгт 4. Насны бүлгээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Насны бүлэг				
	18-25	26-35	36-45	46-55	56-аас дээш
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	24.5%	24.6%	25.9%	27.6%	23.2%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	32.1%	32.8%	32.7%	30.6%	32.3%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	21.2%	17.2%	12.4%	14.7%	19.2%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	4.2%	3.0%	5.2%	3.5%	5.1%
5. Үнэ буурна	1.9%	1.5%	1.6%	0.6%	1.0%
6. Мэдэхгүй	16.0%	20.9%	22.3%	22.9%	19.2%
Нийт	100%	100%	100%	100%	100%

Нийт судалгаанд оролцогчдын хамгийн их нь болох 26-35, 36-45 насны иргэдийн харгалзан 32.8, 32.7 хувь нь 2-р хариултыг, 17.2, 12.4 хувь нь 3-р хариултыг, 3.0, 5.2 хувь нь 4-р хариултыг сонгосон бөгөөд бусдад нь адил хувийн жинтэй хариулсан гэж хэлж болохоор байна. Бусад насны ангиллуудыг харвал 1-р хариултыг 46-55 насныхны 27.6 хувь нь, 56-аас дээш насныхны 23.2 хувь нь сонгожээ. Мөн 6-р хариултанд 46-55 насныхны 22.9 хувь нь, 18-25 насныхны 16 хувь нь хариулжээ. Харин бусад хариултуудын хувьд насны ангиллын ялгаа ажиглагдахгүй байна. Эндээс харахад хамгийн их зөрүүтэй хариулсан нь 3-р хариулт бөгөөд 36-45 насны болон 18-25 насны иргэдийн хариултуудын хооронд 8.8 нэгжээр зөрүүтэй байна.

3.2.3. Боловсролын түвшин

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт боловсролын түвшингээс хамааран ялгаатай байж болох тул гол асуултын дүнг боловсролын түвшингээр ангилан харууллаа. Нийт санал асуулгад оролцогчдын 49.6 хувь нь дээд, 40.2 хувь нь бүрэн дунд, 8.3 хувь нь бүрэн бус дунд, 1.1 хувь нь бага боловсролтой иргэд байсан бол 0.8 хувь нь боловсролгүй иргэд байлаа. Боловсролын түвшинг харахад судалгаанд оролцогчдын 89.6 хувь нь бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд байна.

Нийт судалгаанд оролцсон иргэдээс хамгийн их нь болох дээд боловсролтой иргэдийн 34.7 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 29.6 хувь нь 2-р хариултыг сонгосон байхад хамгийн бага буюу боловсролгүй иргэдийн 25 хувь нь энэ хариултыг сонгожээ. 3-р хариултыг харвал дээд боловсролтой иргэдийн 17.9 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 16.4 хувь нь энэ хариултыг сонгосон байхад боловсролгүй иргэдийн 25 хувь нь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 8.4 хувь нь ийнхүү хариулжээ.

Хүснэгт 5. Боловсролын түвшингээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Боловсролын түвшин				
	Дээд	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Боловсролгүй
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	25.0%	24.6%	32.5%	27.3%	-
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	34.7%	29.6%	30.1%	36.4%	25.0%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	17.9%	16.4%	8.4%	18.2%	25.0%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	3.0%	5.5%	4.8%	-	-
5. Үнэ буурна	1.0%	1.5%	2.4%	-	12.5%
6. Мэдэхгүй	18.3%	22.4%	21.7%	18.2%	37.5%
Нийт	100%	100%	100%	100%	100%

Боловсролгүй иргэдийн хувьд нийт санал асуулгад оролцогчдод маш бага хувийн жин эзэлж байгаа бөгөөд 5 болон 6-р хариултууд дээр хамгийн их нь буюу харгалзан 12.5, 37.5 хувь нь хариулсан байна. Үүнийг эс тооцвол үлдсэн хариултуудын хувьд боловсролын түвшингийн ялгаа ажиглагдахгүй байна. Эндээс харахад судалгаанд оролцогчдын ихэнх нь дээд, бүрэн дунд боловсролтой иргэд байсан бөгөөд хариултуудын хувьд боловсролын ялгаа төдийлэн ажиглагдсангүй, харин 2-р хариултын хувьд 5.1 нэгжээр зөрүүтэй хариулсан нь энэ хоёр ангиллын хувьд хамгийн их нь байлаа. Оролцогчдоос хамгийн бага хувийн жинтэй нь боловсролгүй иргэд байсан бөгөөд тэдний ихэнх хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.

3.2.4. Ажил эрхлэлт

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь ажил эрхлэлтийн байдлаас хамааран ялгавартай байж болох тул гол асуултын дүнг ажил эрхлэлтээр ангилан харуулах нь зүйтэй. ҮСХ-ны мэдээллээр 2008 оны эцэст Монгол улсын хүн ам 2 сая 683.5 мянган хүн ам байснаас хөдөлмөрийн насны хүн ам 1 сая 688.7 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 1 сая 71.5 мянга байсан бөгөөд үүний 1 сая 41.7 мянга нь ажиллагсад байна. Харин нийт судалгаанд оролцогчдын 26.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 24.3 хувь нь ажилгүй, 22.8 хувь нь хувийн байгууллагад, 16.2 хувь нь төрийн байгууллагад, 4.6 хувь нь төрийн бус байгууллагад, 2.7 хувь тэтгэвэрт, 2.4 хувь нь цагийн ажил эрхэлдэг иргэд байсан бол үлдсэн 0.8 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна.

Хүснэгт 6. Ажил эрхлэлтээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ажил эрхлэлт						
	Төрийн алба	Хувиараа	Хувийн байгууллага	Төрийн бус байгууллага	Цагийн ажил	Ажилгүй	Гэтгэвэрт
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	32.1%	21.4%	23.2%	28.3%	16.7%	28.4%	14.8%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	31.5%	33.2%	35.1%	37.0%	37.5%	26.7%	40.7%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	17.3%	18.3%	16.7%	17.4%	29.2%	11.9%	25.9%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	1.9%	4.2%	3.9%	-	4.2%	5.3%	14.8%
5. Үнэ буурна	1.2%	2.3%	0.9%	4.3%	-	0.8%	-
6. Мэдэхгүй	16.0%	20.6%	20.2%	13.0%	12.5%	26.7%	3.7%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Нийт судалгаанд оролцогсдын хамгийн их нь болох хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэд болон хувийн байгууллагад ажиллагсад харгалзан 33.2, 26.7 ба 35.1 хувь нь 2-р хариултыг сонгосон бол судалгаанд оролцогчдын хамгийн бага хувийн жин эзэлж буй цагийн ажил эрхлэгчдийн 37.5 хувь нь ийнхүү хариулжээ. 1-р хариултыг харвал хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 21.4 хувь, ажилгүй иргэдийн 28.4 хувь, хувийн байгууллагад ажиллагсдын 23.2 хувь нь сонгосон бол төрийн албанд ажиллагсдын 32.1 хувь, цагийн ажил эрхлэгчдийн 16.7 хувь нь энэ хариултыг сонгосон байна. 3-р хариултыг харвал ажилгүй иргэдийн 11.9 хувь нь ийнхүү хариулсан байхад цагийн ажил эрхлэгчдийн 29.2 хувь нь ийнхүү хариулжээ. 6-р хариултанд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 20.6 хувь, ажилгүй иргэдийн 26.7 хувь, хувийн байгууллагад ажиллагсдын 20.2 хувь нь хариулжээ. Харин 4 болон 5-р хариултын хувьд ажил эрхлэлтийн ялгаа ажиглагдахгүй байна. Эндээс харахад оролцогчдын хамгийн их нь хувийн хэвшилд ажиллагсад байсан бөгөөд ажилгүйчүүд болон төрийн албанд ажиллагсад мөн нилээдгүй хувийн эзэлж байна. Төрийн албанд ажиллагсдын ихэнх 1-р хариултыг сонгосон бол, ажилгүй иргэдийн ихэнх нь 6 буюу мэдэхгүй гэсэн хариултыг, тэтгэврийн иргэдийн ихэнх нь 2-р хариултыг сонгох хандлагатай байлаа.

3.2.5. Өрхийн орлого

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт өрхийн орлогоос хамаарч байгаа эсэхийг тодруулах үүднээс гол асуулгын дүнг өрхийн орлогоор ангиллаа. ҮСХ-ны мэдээгээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2008 оны эцэст 337.2 мянган төгрөг болж 2007 оныхоос 41 хувь буюу 98 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт санал асуулгад оролцогчдын 26.6 хувь нь 201-300 мянга, 21.6 хувь нь 101-200 мянга, 9.5 хувь нь 100 мянгаас бага орлоготой иргэд байсан нь улсын дунджаас доогуур орлоготой иргэд байна. Харин 19.9 хувь нь 301-400 мянга төгрөгийн буюу дундаж орлоготой, 9.9 хувь нь 500 мянгаас дээш, 9.8 хувь нь

401-500 мянган төгрөгийн орлоготой байгаа нь улсын дунджаас дээгүүр орлоготой байна. Эндээс харвал судалгаанд оролцогсдын 68.1 хувь нь 100-400 мянган төгрөгийн орлоготой иргэд байна. Тэр дундаа 48.2 хувь нь 100-300 мянган төгрөгийн өрхийн орлоготой иргэд байгаа нь үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд байлаа. Харин 1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд 1.7 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна.

Хүснэгт 7. Өрхийн орлогоор (хувь)

Таны бодлоор ирэх 12 сард бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Өрхийн орлого					
	100.0-аас бага	101.0-200.0	201.0-300.0	301.0-400.0	401.0-500.0	500.0-аас дээш
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	30.5%	23.6%	27.8%	19.1%	22.4%	27.3%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	21.1%	31.5%	32.3%	35.7%	36.7%	33.3%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	6.3%	17.6%	20.7%	19.1%	10.2%	16.2%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	6.3%	5.1%	3.0%	3.0%	4.1%	6.1%
5. Үнэ буурна	4.2%	-	1.5%	1.0%	1.0%	1.0%
6. Мэдэхгүй	31.6%	22.2%	14.7%	22.1%	25.5%	16.2%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%

Судалгаанд оролцогсдын хамгийн их нь болох 201-300 мянга, 101-200 мянга болон 301-400 мянган төгрөгийн өрхийн орлоготой иргэд 2-р хариултанд харгалзан 32.3, 31.5 ба 35.7 хувь нь хариулсан бол 100 мянгаас бага өрхийн орлоготой иргэдийн 21.1 хувь, 401-500 мянган төгрөгийн орлоготой иргэдийн 36.7 хувь, 500 мянгаас дээш орлоготой иргэдийн 33.3 хувь нь тус тус сонгожээ. 1-р хариултыг харвал 201-300, 101-200, 301-400 мянган төгрөгийн орлоготой иргэдийн харгалзан 27.8, 23.6 ба 19.1 хувь нь тус тус сонгосон байна. 3-р хариултыг харвал 201-300 мянган орлоготой иргэдийн 20.7 хувь, 101-200 мянгых 17.6 хувь, 301-400 мянгых 19.1 хувь нь ийнхүү хариулсан бол 100 мянгаас бага орлоготой иргэдийн 6.3 хувь нь ийнхүү хариулжээ. 6-р хариултыг харвал 201-300, 101-200, 301-400 мянган орлоготой иргэд харгалзан 14.7, 22.2 ба 22.1 хувь нь хариулсан бол 100 мянгаас бага орлоготой иргэдийн 31.6 хувь нь ийнхүү хариулжээ. Харин 4 болон 5-р хариултуудын хувьд өрхийн орлогын ялгаа ажиглагдахгүй байна. Оролцогчдын талаас илүү хувь нь улсын дунджаас доогуур орлоготой иргэд байсан бөгөөд 100 мянгаас бага орлоготой иргэдийн ихэнх нь мэдэхгүй гэсэн хариултыг өгөх хандлагатай байлаа.

3.3. Бусад асуултуудын дүн

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтэнд нөлөөлж болохуйц нийгэм, эдийн засгийн асуултуудын дүнг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан танилцуулья.

Хүснэгт 8. Таны бодлоор ирэх 12 сард үнийн өсөлт хэдэн хувьд хүрэх вэ?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
0-5	16.6%	21.0%	4.4
6-10	31.2%	30.0%	-1.2
11-15	18.0%	15.7%	-2.3
16-20	11.4%	8.4%	-3.0
21-ээс дээш	15.7%	7.6%	-8.1
Мэдэхгүй	7.1%	17.3%	10.2
Нийт	100.0%	100.0%	-

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд инфляцийг 8 хувьд барина гэсэн зорилтыг тусгасан. Судалгаанд оролцогчдын талаас илүү буюу 51 хувь нь 0-10 хувь байна гэж үзэж байгаа нь төрийн мөнгөний бодлогын зорилттой нийцэж байна. Ялангуяа судалгаанд оролцогчдын 30 хувь нь инфляци 6-10 хувьд байна гэсэн нь 8 хувь гэсэн зорилттой илүү дөхөж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал 0-5 хувьд байна гэсэн хариултын хувийн жин 4.4 нэгжээр өссөн бөгөөд 21-ээс дээш гэсэн хариултынх 8.1 нэгжээр буурчээ. Энэ нь нэг талаас дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөө суларсан, нөгөө талаас Монголын инфляцийн түвшин эрс буурсантай холбоотой байж болох юм. Харин үлдсэн 15.7 хувь нь инфляци 11-15, 16 хувь нь 21 хувиас дээш байна гэж таамагласан байна.

Хүснэгт 9. Танай өрхийн санхүүгийн байдал өмнөх жилтэй харьцуулахад энэ жил ямар байна вэ?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Сайжирсан	10.6%	8.6%	-2.0
Хэвэндээ	39.3%	42.7%	3.4
Муудсан	43.8%	45.2%	1.4
Мэдэхгүй	6.3%	3.5%	-2.8
Нийт	100.0%	100.0%	-

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 45.2 хувь нь “муудсан” гэж хариулсан бөгөөд өмнөх судалгаанаас 1.4 нэгжээр өсчээ. Эндээс санхүү, эдийн засгийн хямралын нөлөө манай улсын өрх гэрийн санхүүд хэрхэн сөргөөр нөлөөлсөн нь харагдаж байна. Мөн байгууллагын цалин хөлс, иргэн хүний орлого өсөөгүй учир өндөр инфляци нөлөөлсөн хэвээр байна. 2008 оны байдлаар ядуурлын түвшин 35.2¹⁰ (930,000 хүн) хувьтай байгаа бөгөөд нэг хүнд ноогдох хэрэглээнд тулгуурлаж тооцдог хэрэглээний тэгш бус байдлыг харуулдаг жини коэффициент¹¹ сүүлийн жилүүдэд өсч байгаа нь (2008 оны байдлаар 0.36¹⁰) эдийн засгийн баялгийн үр шимийг амьдралын боломж илүү сайтай хүмүүс хүртэж байгаагийн илэрхийлэл юм.

¹⁰ UNFPA, 2009. Монгол улс хүн ам ба хөгжлийн бага хурлаас хойших 15 жилд

¹¹ 0 утга нь тэгш бус байдал байхгүйг, 1 гэсэн утга нь тэгш бус байдал дээд цэгтээ байгааг тус тус илэрхийлнэ

Харин хямралын үед өрх гэрийн санхүүгийн байдал муудсангүй хэвэндээ гэж 42.7 хувь нь хариулсан нь чамлахааргүй үзүүлэлт бөгөөд 3.4 нэгжээр өссөн байна. Оролцогчдын 8.6 хувь нь сайжирсан гэсэн бол 3.5 хувь нь мэдэхгүй гэсэн хариултаадыг өгчээ.

Хүснэгт 10. Хэрэв сайжирсан бол шалтгаан нь юу вэ?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Цалин нэмэгдсэн	53.2%	54.7%	1.5
Бизнесийн орлого нэмэгдсэн	36.0%	46.5%	10.5
Үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн	6.3%	3.5%	-2.8
Ам бүлийн тоо цөөрсөн	4.5%	3.5%	-1.0
Үнэ буурсан	1.8%	1.2%	-0.6
Нийт	101.8%	109.3%	7.5

Сайжирсан гэж иргэдийн 8.6 хувь нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээр хэрэглэгчдийн ихэнх нь цалин нэмэгдсэн, бизнесийн орлого өссөн гэсэн шалтгаануудыг дурьдсан бөгөөд бизнесийн орлого өссөн гэсэн хариултынх 10.5 нэгжээр өссөн байна.

Хүснэгт 11. Хэрэв муудсан бол шалтгаан нь юу вэ?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Цалин болон бизнесийн орлого буурсан	28.8%	39.8%	11.0
Үл хөдлөх хөрөнгийн үнэ буурсан	4.6%	5.1%	0.5
Ам бүлийн тоо нэмэгдсэн	6.1%	7.7%	1.6
Үнэ өссөн	73.6%	63.1%	-10.5
Нийт	113.1%	115.7%	2.6

Муудсан гэж иргэдийн 45.2 хувь нь хариулсан бөгөөд тэдгээрээс давхардсан тоогоор хамгийн их нь буюу 63.1 хувь нь үнийн өсөлтөөс болсон гэж тайлбарласан байна. 2008 онд үнийн өсөлт сүүлийн 10 жилд байгаагүй өндөр түвшинд хүрсэн нь иргэдийн амьжиргаанд хэрхэн сөргөөр нөлөөлсөн нь харагдаж байна. Мөн хямралын үед дэлхий даяар хэрэглээ буурснаас эрэлт буурч, энэ нь бизнесийн орлого буурахад нөлөөлсөн байна. Үнэ өссөн гэсэн хариултынх 10.5 нэгжээр буурсан байхад, цалин болон орлого буурснаас болсон гэсэн хариулт 11.0 нэгжээр өссөн байна.

“Танай өрхийн санхүүгийн байдал ирэх жил энэ жилтэй харьцуулахад сайжрах болов уу” гэсэн асуултанд нийт иргэдийн ихэнх нь буюу 45.1 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан нь дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэж ирээдүйн тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм. Нийт асуулгад оролцогчдын 23.7 хувь нь ирэх жил манай өрхийн санхүүгийн байдал “сайжирна” гэж хариулсан байна. Энэ нь инфляци буурч доогуур түвшинд тогтворжсон, ОУВС-ийн таамаглалаар¹² манай улсын ДНБ өсөх хандлагатай байгаа зэрэг эдийн засгийн төлөв байдал сайжирсантай холбоотой байх

¹² IMF. 2009 October, “World Economic Outlook - Sustaining the Recovery”

магадлалтай. Харин нийт судалгаанд оролцогчдын 22.2 хувь нь “хэвэндээ байна”, 9 хувь нь “муудна” гэсэн хариулт өгсөн нь эдийн засгийн хямралаас үлдсэн хүлээлт байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 12. Таны бодлоор эдийн засгийн ерөнхий байдлыг авч үзвэл одоо хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Тийм	11.5%	16.1%	4.6
Үгүй	51.2%	45.1%	-6.1
Мэдэхгүй	34.4%	38.8%	4.4
Хариулт өгөөгүй	2.9%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Нийт иргэдийн 16.1 хувь нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе хэмээн үзсэн бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 4.6 нэгжээр өссөн байгаагаас харвал иргэдийн банкинд итгэх итгэл бага зэрэг нэмэгдсэн гэж хэлж болохор байна. Иргэдийн ихэнх нь буюу 45.1 хувь нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй байна гэж хариулсан бөгөөд өмнөх судалгаанаас 6.1 нэгжээр буурсан байна. Сүүлийн үед инфляцийн түвшин эрс буурч 2009 оны 9 сарын байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасч тооцсон бодит хүү 15.1 хувьтай гарч, иргэдийн хадгаламжийг төр батлан даах хууль батлагдсан, мөн 2008 оны 9 сараас нийт хадгаламжийн өсөлт саарч 2008 оны эцэст -10.1 хувьд хүрсэн бол 2009 оны эхнээс эргэн нэмэгдэж 9 сарын эцэст жилийн өсөлт 5.7 хувьд хүрсэн байна. Эндээс харахад нийт хадгаламжийн хэмжээ өсч, хадгаламжинд мөнгөө байршуулах тохиромжтой нөхцөл бүрдсэн хэдий ч иргэдийн нилээд хэсэг нь банкинд мөнгөн хуримтлал хийхэд тохиромжгүй хэмээн үзсэн байна. Энэ нь хямралаас үүдэн иргэдийн орлого буурснаас болж иргэд мөнгөн хуримтлал хийх боломжгүй болсонтой холбоотой байх талтай. Түүнчлэн 2008 оны эцсээр Анод банкны үйл ажиллагааны нөхцөл байдал хүндэрсэн нь иргэдийн банкинд итгэх итгэлийг сулруулсантай холбоотой байж болох юм. Харин үлдсэн 38.8 хувь нь “мэдэхгүй” гэжээ.

Хүснэгт 13. Та ирэх 12 сарын хугацаанд мөнгө хадгална гэж бодож байна уу?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Тийм	15.7%	26.0%	10.3
Тэгэх байх	15.8%	21.9%	6.1
Үгүй байх	19.5%	21.6%	2.1
Үгүй	34.6%	21.2%	-13.4
Мэдэхгүй	13.1%	9.3%	-3.8
Хариулт өгөөгүй	1.3%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Хариултуудаас харахад санал асуулгад оролцогчдын 47.9 хувь нь “тийм”, “тэгэх байх” гэж хариулсан бөгөөд өмнөх судалгаанаас 16.4 нэгжээр өссөн байна. Энэ нь судалгаанд оролцогчдын тал хувь нь ирээдүйд хадгаламжинд мөнгө хийх нөхцөл бүрдэж, хадгаламжинд хийх мөнгөн орлоготой болно гэсэн хүлээлттэй байгааг харуулж байна. Сүүлийн үед эдийн засгийн хямралын нөлөөлөл буурч, төгрөгийн ханш тогтворжсон, мөн инфляци доогуур тогтвортой түвшинд очсон зэрэг нь хадгаламжинд мөнгө хийх тохиромжтой нөхцлийг бүрдүүлж өгч байна. Мөн нийт судалгаанд оролцогчдын 42.8 хувь нь ирэх 12 сард мөнгө хадгалах нөхцөл бүрдэхгүй гэж үзсэн бөгөөд өмнөх судалгаанаас 11.3 нэгжээр буурсан байна. Харин 9.3 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ.

Хүснэгт 14. Таны бодлоор манай улсын эдийн засаг өнгөрсөн онд сайжирсан уу?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Сайжирсан	12.1%	8.1%	-4.0
Хэвэндээ байна	34.2%	37.1%	2.9
Муудсан	47.5%	51.7%	4.2
Хариулт өгөөгүй	6.2%	3.1%	-3.1
Нийт	100.0%	100.0%	-

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь буюу 51.7 хувь нь манай орны эдийн засаг өнгөрсөн онд “муудсан” гэж хариулсан бөгөөд энэ нь өмнөх судалгааны дүнгээс 4.2 нэгжээр өссөн байна. Өнгөрсөн онд эдийн засгийн хямралын нөлөөгөөр эдийн засгийн салбарууд зогсонги байдалд орсон, мөн өрхийн орлого багасаж иргэдийн худалдан авах чадвар муудсан зэрэг олон сөрөг нөлөөллүүд гарч байсан. Мөн инфляци 32.4 хувьд хүрч сүүлийн 10 жилд байгаагүй өндөр түвшинд хүрсэн, эдийн засгийн өсөлт саарсан, мөн зээлийн хүрээ хумигдаж банкууд зээлийн хэрэгцээгээ хангаж чадахгүйд хүрсэн зэрэг нөлөө нь одоо ч гэсэн үргэлжилсээр байна. Энэ мэт хүчин зүйлүүдээс хамаарч судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь ийнхүү хариулсан байх талтай. Мөн дээр дурдсанчлан судалгаанд оролцогчдын тал хувь нь өрхийн санхүүгийн байдал үнийн өсөлт болон цалин, бизнесийн орлого буурснаас шалтгаалан муудсан гэсэн хариултыг өгсөн нь энэ үр дүнг батлан харуулж байна. Харин судалгаанд оролцогчдын 37.1 хувь нь эдийн засаг өмнөх онтой харьцуулахад “хэвэндээ байна” гэж хариулсан байна.

Хүснэгт 15. Таны бодлоор манай улсын эдийн засаг ирэх жил ямар байх бол?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Сайжирна	7.8%	9.7%	1.9
Сайжрах нөхцөл бүрдэнэ	19.8%	31.5%	11.7
Хэвэндээ байна	17.4%	17.5%	0.1
Муудах байх	24.4%	11.4%	-13.0
Мэдэхгүй	29.9%	29.9%	0.0
Хариулт өгөөгүй	0.7%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Нийт хэрэглэгчдийн 41.2 хувь нь “Сайжирна”, “Сайжрах нөхцөл бүрдэнэ” гэсэн хариултыг өгсөн бөгөөд эдгээр хариултуудын хувийн жин өмнөх судалгаанаас 13.6 нэгжээр өссөн байна. Энэ нь хэрэглээний барааны үнийн өсөлт буурч доогуур тогтвортой түвшинд очсон, засгийн газраас ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглалтанд оруулах талаар алхмуудыг хийсэн нь ирээдүйн хөрөнгө оруулалтын хүлээлтийг нэмэгдүүлсэн, мөн ОУВСангаас манай улсын санхүүгийн зах зээлийн хямралыг багасгах үүднээс зээл тусламжуудыг оруулж эхэлсэн зэрэг эерэг мэдээллүүдээс үүдэлтэй байж болох юм. ОУВС-гийн тайлангаас харахад манай улсын ДНБ-ий өсөлтийн ирэх 2010, 2011 онуудад өсөх хандлагатай байгаа юм. Харин дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр өнгөрсөн онд эдийн засгийн нөхцөл байдал муудсантай холбоотойгоор иргэдийн 38.9 хувь нь эдийн засаг “хэвэндээ байна”, “муудах байх” гэж хариулсан байх талтай.

Хүснэгт 16. Засгийн газар эдийн засгийн байдлыг сайжруулах арга хэмжээ авч чадаж байна уу?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Чадаж байна	6.6%	7.5%	0.9
Тааруухан байна	44.0%	50.5%	6.5
Чадахгүй байна	37.2%	30.4%	-6.8
Мэдэхгүй	10.7%	11.6%	0.9
Хариулт өгөөгүй	1.5%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 80.9 хувь нь Засгийн газрын эдийн засгийн талаар авч байгаа бодлого арга хэмжээнд ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа нь тод харагдаж байна. Гэсэн хэдий ч Засгийн газар Оюу-Толгойн орд газрыг ашиглалтанд оруулах гэрээг баталж эдийн засагт баялаг бий болгох нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд “чадахгүй байна” гэсэн хариулт өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 6.8 нэгжээр буурсан нь нааштай үзүүлэлт болж байна.

Хүснэгт 17. Та Монголбанкны мэдээлэл, зорилтот үзүүлэлтүүдэд итгэдэг үү?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Тийм	15.5%	17.6%	2.1
Бага зэрэг	41.2%	42.9%	1.7
Үгүй	25.6%	21.2%	-4.4
Мэдэхгүй	17.3%	18.3%	1.0
Хариулт өгөөгүй	0.4%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Нийт судалгаанд оролцогчдын 42.9 хувь нь “бага зэрэг” итгэдэг гэж хариулсан бөгөөд өмнөх судалгаанаас 1.7 нэгжээр өссөн байна. Харин 17.6 хувь нь итгэдэг гэсэн бөгөөд 2.1 нэгжээр өссөн байна. Энэ нь төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг нэг оронтой тоонд барина гэсэн зорилтын хүрээнд сүүлийн үед инфляци буурч зорилтот түвшиндээ байгаатай холбоотой байж болох юм. Мөн

Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээг олон нийтэд шуурхай хүргэх үүднээс өөрийн вэб сайт болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд байршуулж байгаа билээ. Харин судалгаанд оролцогчдын 21.2 хувь нь итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 18. Таны бодлоор ирэх онд ажилгүйдэл нэмэгдэх үү?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Нэмэгдэнэ	46.2%	44.7%	-1.5
Хэвэндээ байна	21.5%	19.6%	-1.9
Буурна	8.5%	8.8%	0.3
Мэдэхгүй	23.1%	26.9%	3.8
Хариулт өгөөгүй	0.7%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Нийт судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь буюу 44.7 хувь нь ирэх онд ажилгүйдэл нэмэгдэнэ гэж үзжээ. Энэ хариултыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал 1.5 нэгжээр буурчээ. ҮСХ-ны мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2009 оны 9 сарын эцэст 40.4 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 27.1 хувиар өсчээ. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөнөөс аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл удааширч, зарим нь зогсонги байдалд орсон бөгөөд хувийн хэвشلүүд хаалгаа барьж эхэлсэн билээ. Харин 8.8 хувь нь ирэх онд ажилгүйдэл “буурна” гэж үзжээ.

Хүснэгт 19. Таны бодлоор ирэх жил банкны зээлийн хүү өсөх үү?

	2008 он 12 сар	2009 он 9 сар	Өөрчлөлт
Өснө	37.3%	26.7%	-10.6
Хэвэндээ байна	16.0%	19.7%	3.7
Буурна	10.4%	9.6%	-0.8
Мэдэхгүй	35.9%	44.0%	8.1
Хариулт өгөөгүй	0.4%	-	-
Нийт	100.0%	100.0%	-

Нийт судалгаанд оролцогчдын 26.7 хувь нь ирэх жил банкуудын зээлийн хүү “өснө” гэсэн хүлээлттэй байгаа бөгөөд өмнөх судалгаанаас 10.6 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Харин 19.7 хувь нь “хэвэндээ байна”, 9.6 хувь нь “буурна” гэсэн хүлээлттэй байгаа бол 44 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгчээ. Санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан аж ахуйн нэгж, иргэд авсан зээлээ эргэн төлөхөд хүнд болж ирсэн. Үүнээс шалтгаалан банкуудын зээлийн эргэн төлөлт зогсож банкууд зээлийн хүүгээ өсгөж эхэлсэн. Нөгөө талаас зээлийн хүүний өсөлтөнд 2008 оны инфляцийн өндөр өсөлт мөн нөлөөлсөн байх талтай.

4. Аж ахуйн нэгж, байгууллагуудын инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүн

Судалгааны ажлын санал асуулгын түүврийг 2009 оны 9 дүгээр сарын 1-нээс 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллагуудаас санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцох байгууллагыг сонгон хаягаар очиж санал асуулгыг авсан. Санамсаргүй түүврийн арга нь статистик болон математик аргачлалаар нийт бүхлийг төлөөлөх чадвартай цөөн тооны субъектыг сонгон судалгаанд хамруулдагаараа цаг хугацаа, хөрөнгө мөнгө болон хөдөлмөр хэмнэдэг давуу талтай.

Санал асуулгад 390 аж ахуйн нэгж оролцсоны 93.3 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 2.8 хувь нь бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 2.3 хувь нь хувьцаат компани, 1.3 хувь нь зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 0.3 хувь нь хоршоод байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагуудын 91.5 хувь нь дотоодын, 3.3 хувь нь гадаадын, 5.1 хувь нь дотоод болон гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай, 4.6 хувь нь охин компанитай бол 95.4 хувь нь охин компанигүй байна. Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 84.1 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээгээ дотооддоо үйлдвэрлэдэг, 4.9 хувь нь гадаадаас импортолдог, 11 хувь нь дотооддоо үйлдвэрлэхээс гадна импортолдог байна.

Санал асуулганд оролцсон компаниуд дараахь тооны ажилчидтай байна.

Хүснэгт 20. Танай компанид хэдэн хүн ажилладаг вэ?

10 хүртэл	286
10-100	82
100-200	5
200аас дээш	5
1000аас дээш	1
Хариулаагүй	11

Санал асуулгад оролцогсдын 53.3 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд тухайн компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт буурсан гэж хариулсан бол 32.1 хувь нь өөрчлөгдөөгүй, 14.1 хувь нь өссөн, 0.5 хувь нь хариулаагүй байна. Оны эхний санал асуулгатай харьцуулахад буурсан гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хариулт 1.8 хувиар буурч, өссөн гэдэг хариулт 0.8 хувиар өсчээ. Энэ нь өнгөрсөн 6 сарын хугацаанд буюу I улирлын санал асуулгаас хойш аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт ялимгүй өссөн болохыг харуулж байна.

Хүснэгт 21. Өнгөрсөн 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт хэрхэн өөрчлөгдсөн бэ?

		Өссөн	Өөрчлөгдөөгүй	Буурсан	Хариулаагүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/ үйлчилгээ үзүүлдэг	2009.I	14.1%	32.2%	53.7%	0%
	2009.III	15.2%	33.8%	50.6%	0.3%
	Өөрчлөлт	1.1	1.6	-3.1	0.3
Импортлодог	2009.I	8.1%	27%	64.9%	0%
	2009.III	5.3%	15.8%	78.9%	0%
	Өөрчлөлт	-2.8	-11.2	14	0
Аль аль нь	2009.I	12.3%	31.6%	56.1%	0%
	2009.III	9.3%	25.6%	62.8%	2.3%
	Өөрчлөлт	-3	-6	6.7	2.3
Бүгд	2009.I	13.3%	31.6%	55.1%	0%
	2009.III	14.1%	32.1%	53.3%	0.5%
	Өөрчлөлт	0.8	0.5	-1.8	0.5

Харин ирэх 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт хэрхэн өөрчлөгдөх вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 25.1 хувь нь өснө, 22.6 хувь нь өөрчлөгдөхгүй, 35.6 хувь нь мэдэхгүй, 15.6 хувь нь буурна гэж хариулсан байна. Аж ахуйн нэгжүүдийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр нь харвал гадаадаас импортлодог компаниудыг дотооддоо үйлдвэрлэл/үйлчилгээ үзүүлдэг компаниудтай харьцуулахад бараа бүтээгдэхүүнийхээ эрэлтийг харьцангуй буурна гэсэн хүлээлттэй харагдаж байна. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн дотооддоо үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн/үйлчилгээ, гадаадаас импортлох бүтээгдэхүүнээс өрсөлдөх чадвар өндөртэй байна гэсэн үг юм. Үүнийг даган гадаадаас импортлох бүтээгдэхүүн буурах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 22. Таны бодлоор ирэх 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт ямар байх вэ?

		Өснө	Өөрчлөгдөөгүй	Мэдэхгүй	Буурна	Хариулаагүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/ үйлчилгээ үзүүлдэг	2009.I	26.2%	17.8%	40.9%	15.1%	0%
	2009.III	26.5%	22.6%	34.5%	15.2%	1.2%
	Өөрчлөлт	0.3	4.8	-6.4	0.1	1.2
Импортлодог	2009.I	27.0%	8.1%	35.1%	29.7%	0%
	2009.III	21.1%	15.8%	42.1%	21.1%	0%
	Өөрчлөлт	-5.9	7.7	7	-8.6	0
Аль аль нь	2009.I	17.5%	17.5%	45.6%	19.3%	0%
	2009.III	16.3%	25.6%	41.9%	16.3%	0%
	Өөрчлөлт	-1.2	8.1	-3.7	-3	0
Бүгд	2009.I	25.0%	16.8%	41.1%	17.1%	0%
	2009.III	25.1%	22.6%	35.6%	15.6%	1.0%
	Өөрчлөлт	0.1	5.8	-5.5	-1.5	1

Ирэх 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт ямар байх вэ гэсэн асуултанд өгсөн хариултын шалтгааныг асуухад өснө гэж хариулсан компаниудын 63.3 хувь нь улирлын шинжтэй эрэлтийн өсөлтөөс шалтгаалж өснө, 28.6 хувь нь бүтээгдэхүүний эрэлтийн тогтвортой өсөлттэй холбоотой өснө гэсэн бол буурна гэж хариулсан компаниудын 39.3 хувь нь улирлын шинжтэй буурна, 37.7 хувь нь бүтээгдэхүүний эрэлт буурч байгаатай холбоотой буурна гэж хариулсан байна. Бүтээгдэхүүний эрэлт буурч байгаатай холбоотой буурна гэсэн хариулт өмнөх удаагийн судалгаатай харьцуулахад 29.5 хувиар буурсан байгаа нь иргэдийн худалдан авах чадвар өмнөх удаагийн судалгаатай харьцуулахад сэргэсэн байгааг харуулж байна.

Хүснэгт 23. Та яагаад ингэж бодов?

		Өснө	Өөрчлөгдөөгүй	Мэдэхгүй	Буурна	Хариулаагүй
Улирлын шинжтэй эрэлтийн өсөлтөөс шалтгаалж өснө	2009.I	68.4%	7.6%	22.4%	3.0%	0%
	2009.III	63.3%	9.1%	15.8%	6.6%	0%
	Өөрчлөлт	-5.1	1.5	-6.6	3.6	0
Бүтээгдэхүүний эрэлтийн тогтвортой өсөлттэй холбоотой өснө	2009.I	28.6%	4.5%	2.5%	1.5%	0%
	2009.III	28.6%	3.4%	7.9%	1.6%	0%
	Өөрчлөлт	0	-1.1	5.4	0.1	0
Өөрчлөгдөхгүй	2009.I	0%	54.5%	19.3%	4.5%	0%
	2009.III	3.1%	55.7%	21.6%	9.8%	25.0%
	Өөрчлөлт	3.1	1.2	2.3	5.3	25
Улирлын шинжтэй буурна	2009.I	1.0%	7.6%	10.6%	23.9%	0%
	2009.III	0%	11.4%	17.3%	39.3%	25.0%
	Өөрчлөлт	-1	3.8	6.7	15.4	25
Бүтээгдэхүүний эрэлт буурч байгаатай холбоотой буурна	2009.I	1.0%	19.7%	26.7%	67.2%	0%
	2009.III	1.0%	10.2%	16.5%	37.7%	0%
	Өөрчлөлт	0	-9.5	-10.2	-29.5	0
Хариулаагүй	2009.I	1.0%	6.1%	18.6%	0%	0%
	2009.III	4.1%	10.2%	20.9%	4.9%	50.0%
	Өөрчлөлт	3.1	4.1	2.3	4.9	50

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын 98 хувь нь Засгийн газраас 2007 оны 7 сард батлуулсан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар жижиг, дунд үйлдвэрт хамрагддаг. Энэ удаагийн санал асуулганд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагуудын 97 хувь нь мөн энэ ангилалд хамрагдаж байна. Санал асуулганд оролцогсдоос ирэх улиралд компанийнхаа ажилчдын тоог нэмэх эсэхийг асуухад 17.7 хувь нь нэмнэ, 72.1 нь үгүй, 8.5 хувь нь ажилчдынхаа тоог цөөлнө гэж хариулсан байна.

Харин танай компани ирэх улиралд ажилчдынхаа цалинг нэмэх төлөвтэй байна уу гэсэн асуултанд нийт оролцогсдын 114 буюу 29.2 хувь нь нэмнэ, 276 буюу 70.8 хувь нь үгүй гэж

хариулсан байна. Энэ нь I улирлын санал асуулгатай харьцуулахад цалингаа нэмнэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хариулт 10.6 хувиар, цалингаа нэмэхгүй гэсэн хариулт мөн хувиар буурчээ. Цалингаа нэмнэ гэж хариулсан байгууллагуудын 64.9 хувь нь 10 хүртэл хувиар, 23.7 хувь нь 10-19 хувь, 7 хувь нь 20-29 хувь, 4.5 хувь нь 30-аас дээш хувиар нэмнэ гэсэн байна. Харин цалингаа нэмэх хувийн хэмжээ бага хувь руугаа жин нь шилжсэн байгаа нь I улирлын санал асуулгыг явуулах үед өндөр инфляцитай байсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 20. Хэрэв дараагийн улиралд цалингаа нэмэх бол хэдэн хувиар нэмэх вэ?

		10%>	10-19%	20-29%	30%
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	43.9%	33.3%	10.5%	12.3%
	2009.III	64.6%	23.2%	8.1%	4.0%
	Өөрчлөлт	20.7	-10.1	-2.4	-8.3
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	66.7%	0%	0%	33.3%
	2009.III	71.4%	28.6%	0%	0%
	Өөрчлөлт	4.7	28.6	0	-33.3
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	46.2%	15.4%	38.5%	0%
	2009.III	62.5%	25.0%	0%	12.5%
	Өөрчлөлт	16.3	9.6	-38.5	12.5
Бүгд	2009.I	45.2%	28.8%	15.1%	11.0%
	2009.III	64.9%	23.7%	7.0%	4.4%
	Өөрчлөлт	19.7	-5.1	-8.1	-6.6

Цалингаа нэмнэ гэж хариулсан гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 71.4 хувь нь 10 хүртэл хувь, 28.6 хувь нь 10-19 хувь нэмнэ гэсэн бол дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын 64.5 хувь нь 10 хүртэл хувь, 23 хувь нь 10-19 хувь, 8.1 хувь нь 20-29 хувь, 4 хувь нь 30-аас дээш хувь нэмнэ гэж хариулсан байна. Энэ нь дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаас илүүтэйгээр ажилчдынхаа цалин хөлсний асуудалд уян хатан ханддаг, ашигтай ажилласан болон шаардлагатай үед цалингаа өндөр хувиар нэмэх сонирхолтой байдгийг харуулж байна. Цалингаа нэмнэ гэж хариулсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 87 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай, 6 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 7 хувь нь дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагууд байна.

Нийт санал асуулгад оролцогсдын 49.2 хувь нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хэмжээгээ нэмэхгүй гэж хариулсан бол 13.3 хувь нь нэмнэ, 14.9 хувь нь хэвэндээ байна, 22.6 хувь нь хариулаагүй байна. Эндээс ирэх 12 сард зээлийн эрэлт өнгөрсөн 12 сартай харьцуулахад саарах төлөвтэй байна. Зээлийн хэмжээгээ нэмнэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн 91.5 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай, 5.1 хувь нь дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай, 3.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байгаа нь дотоодын хөрөнгө оруулалттай компаниудыг гадаадын хөрөнгө оруулалттай

компаниудтай харьцуулахад хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай, зээл авах сонирхол ихтэй байдаг нь харагдаж байна.

Хүснэгт 21. Ирэх 12 сарын хугацаанд танай компанийн зээлийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байна вэ?

		Өснө	Хэвэндээ байна	Буурна	Хариулаагүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	22.1%	63.4%	14.5%	0%
	2009.III	13.2%	49.3%	14.3%	23.2%
	Өөрчлөлт	-8.9	-14.1	-0.2	23.2
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	17.4%	56.5%	26.1%	0%
	2009.III	15.4%	53.8%	15.4%	15.4%
	Өөрчлөлт	-2	-2.7	-10.7	15.4
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	32.7%	53.8%	13.5%	0%
	2009.III	15.0%	45.0%	25.0	15.0%
	Өөрчлөлт	-17.7	-8.8	11.5	15
Бүгд	2009.I	23.2%	61.7%	15.1%	0%
	2009.III	13.3%	49.2%	14.9%	22.6%
	Өөрчлөлт	-9.9	-12.5	-0.2	22.6

Ирэх 12 сарын хугацаанд танай компанийн бэлэн мөнгөний хэмжээ хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байна вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 30.5 хувь нь өснө, 48.7 хувь нь хэвэндээ байна, 15.4 хувь нь буурна 0.5 хувь нь төлөвлөж мэдэхгүй, 4.9 хувь нь хариулаагүй байна. Харин оны эхний улиралд явуулсан санал асуулгаар өснө гэсэн хариулт 0.9 хувиар, буурна гэсэн хариулт 8.6 хувиар өсч, хэвэндээ байна гэсэн хариулт 5.6 хувиар, төлөвлөж мэдэхгүй байна гэсэн хариулт 2.8 хувиар тус тус буурсан байна.

Харин тухайн байгууллагаас ирэх 6 сард томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх эсэх төлөвлөгөөг нь асуухад 28.5 хувь нь тийм, 69.2 хувь нь үгүй, 2.3 хувь нь хариулаагүй байна. Энэ нь өмнөх санал асуулгатай харьцуулахад тийм гэсэн хариулт 8 хувиар буурч, үгүй гэсэн хариулт 5.7 хувиар өссөн байна. Хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй байгууллагуудаас хөрөнгө оруулалтаа хэрхэн санхүүжүүлэх вэ гэж асуухад 14.6 хувь нь банкны зээлээр, 8.7 хувь нь компани өөрийн хөрөнгөөр, 2.6 хувь нь гадаад эх үүсвэрээр, 2.6 хувь нь банкны бус зээлээр гэж хариулсан бол 2.3 нь хариулт өгөөгүй байна.

Хүснэгт 22. Хэрэв ирэх 6 сард томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байвал хаанаас санхүүжүүлэх вэ?

		Банкны зээлээр	Компани өөрийн хөрөнгөөр	Үнэт цаасны арилжаагаар	Хувьцаагаар	Гадаад эх үүсвэрээр	Банкны бус зээлээр	Хариулаагүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	53.2%	20.2%	2.8%	2.8%	11.9%	9.2%	0%
	2009.III	50.0%	28.6%	0%	0%	7.1%	8.9%	5.4%
	Өөрчлөлт	-3.2	8.4	-2.8	-2.8	-4.8	-0.3	5.4
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	12.5%	37.5%	0%	0%	50.0%	0%	0%
	2009.III	20.0%	0%	0%	0%	40.0%	0%	40.0%
	Өөрчлөлт	7.5	-37.5	0	0	-10	0	40
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	38.5%	19.2%	0%	11.5%	26.9%	3.8%	0%
	2009.III	0%	66.7%	0%	0%	0%	0%	33.3%
	Өөрчлөлт	-38.5	47.5	0	-11.5	-26.9	-3.8	33.3
Бүгд	2009.I	48.3%	21.0%	2.1%	4.2%	16.8%	7.7%	0%
	2009.III	47.5%	28.3%	0%	0%	8.3%	8.3%	7.5%
	Өөрчлөлт	-0.8	7.3	-2.1	-4.2	-8.5	0.6	7.5

Дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын 50.6 хувь нь хөрөнгө оруулалтаа банкны зээлээр санхүүжүүлнэ гэсэн бол гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 80.0 хувь нь гадаад эх үүсвэрээс болон банкны бус зээлээр, дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 66.7 хувь компани өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэж хариулсан байна. Эндээс дүгнэхэд банкны зээлийг мөн дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд илүү хэрэглэдэг байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд энэ удаагийн санал асуулгад өөрийн хөрөнгөөр нэмэлт хөрөнгө оруулалт хийхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 23. Энэ жил танай компанийн зээлийн эрэлт өнгөрсөн онтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?

		Их хэмжээгээр өссөн	Бага зэрэг өссөн	Адил хэмжээнд байгаа	Бага зэрэг буурсан	Их хэмжээгээр буурсан
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	8.5%	29.3%	42.9%	15.5%	3.8%
	2009.III	9.5%	34.3%	36.9%	16.4%	2.9%
	Өөрчлөлт	1	5	-6	0.9	-0.9
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	4.3%	21.7%	65.2%	8.7%	0%
	2009.III	0%	30.0%	20.0%	30.0%	20.0%
	Өөрчлөлт	-4.3	8.3	-45.2	21.3	20
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	13.5%	28.8%	36.5%	19.2%	1.9%
	2009.III	11.8%	41.2%	35.3%	11.8%	0%
	Өөрчлөлт	-1.7	12.4	-1.2	-7.4	-1.9
Бүгд	2009.I	8.9%	28.8%	43.4%	15.6%	3.3%
	2009.III	9.3%	34.6%	36.2%	16.6%	3.3%
	Өөрчлөлт	0.4	5.8	-7.2	1	0

Зээлийн эрэлтийг өнгөрсөн санал асуулгатай харьцуулахад дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд бага зэрэг өссөн бол гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд хэвэндээ байна. Харин дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд бага зэрэг өсчээ.

Хүснэгт 24. Зээлийн олдоц энэ жил өнгөрсөн жилтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна вэ?

		Илүү олдоцтой болсон	Бага зэрэг сайжирсан	Өөрчлөг- дөөгүй	Бага зэрэг хэцүү болсон	Илүү хэцүү болсон	Мэдэхгүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	3.5%	8.2%	18.6%	27.4%	31.2%	11.1%
	2009.III	2.1%	11.6%	28.5%	35.2%	22.2%	0.4%
	Өөрчлөлт	-1.4	3.4	9.9	7.8	-9	-10.7
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	0%	4.3%	21.7%	34.8%	21.7%	17.4%
	2009.III	0%	0%	37.5%	37.5%	25.0%	0%
	Өөрчлөлт	0	-4.3	15.8	2.7	3.3	-17.4
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	3.8%	3.8%	23.1%	38.5%	21.2%	9.6%
	2009.III	0%	13.3%	26.7%	40.0%	20.0%	0%
	Өөрчлөлт	-3.8	9.5	3.6	1.5	-1.2	-9.6
Бүгд	2009.I	3.3%	7.4%	19.4%	29.3%	29.3%	11.2%
	2009.III	2.0%	11.4%	28.7%	35.5%	22.1%	0.3%
	Өөрчлөлт	-1.3	4	9.3	6.2	-7.2	-10.9

Зээлийн олдоцын хувьд өнгөрсөн санал асуулгатай харьцуулахад энэ оны III улиралд дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд зээлийн олдоц бага зэрэг хэцүү болсон бол гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд өөрчлөлт гараагүй, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд зээлийн олдоц бага зэрэг сайжирсан байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад банкуудын зээл олголт буурсантай холбоотойгоор дотоодын хөрөнгө оруулалттай компаниудад зээлийн олдоц буурсан байна.

Хүснэгт 25. Танай компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ энэ жил өнгөрсөн жилтэй харьцуулахад хэдэн хувиар өөрчлөгдсөн бэ?

		Буурсан 6>	Буурсан 5 хүртэл	Үнэ өөрч- лөгдөөгүй	Өссөн 5 хүртэл	Өссөн 6-10	Өссөн 11-15	Өссөн 16>	Хариу- лаагүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/ үйлчилгээ үзүүлдэг	2009.I	10.4%	9.4%	31.5%	15.4%	18.5%	11.4%	3.4%	0%
	2009.III	9.1%	8.5%	25.3%	27.1%	13.1%	7.6%	5.2%	4.0%
	Өөрчлөлт	-1.3	-0.9	-6.2	11.7	-5.4	-3.8	1.8	4
Импортолдог	2009.I	13.5%	29.7%	21.6%	16.2%	8.1%	8.1%	2.7%	0%
	2009.III	10.5%	5.3%	26.3%	15.8%	15.8%	10.5%	15.8%	0%
	Өөрчлөлт	-3	-24.4	4.7	-0.4	7.7	2.4	13.1	0

Аль аль нь	2009.I	14.0%	15.8%	17.5%	22.8%	10.5%	12.3%	7.0%	0%
	2009.III	9.3%	11.6%	20.9%	27.9%	20.9%	0%	2.3%	7.0%
	Өөрчлөлт	-4.7	-4.2	3.4	5.1	10.4	-12.3	-4.7	7.0
Бүгд	2009.I	11.2%	12.2%	28.6%	16.6%	16.3%	11.2%	3.8%	0%
	2009.III	9.2%	8.7%	24.9%	26.7%	14.1%	6.9%	5.4%	4.1%
	Өөрчлөлт	-2	-3.5	-3.7	10.1	-2.2	-4.3	1.6	4.1

Дотооддоо үйлдвэрлэл/үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд энэ жилийн 9 дүгээр сараас өнгөрсөн жилийн 9 дүгээр сарын хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.1 хувь нь 5 хүртэл хувиар, 13.1 хувь нь 6-10 хувиар, 7.6 хувь нь 11-15 хувиар, 5.2 хувь нь 16-аас дээш хувиар үнээ өсгөсөн, 25.3 хувь нь үнээ өөрчлөөгүй, 9.1 хувь нь 6-аас дээш хувиар, 8.5 хувь нь 5 хүртэл хувиар үнээ буулгасан бол 4 хувь нь хариулаагүй байна. Бараа бүтээгдэхүүнээ импортолдог байгууллагуудын хувьд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээ 15.8 хувь нь 5 хүртэл хувиар, 15.8 хувь нь 6-10 хувиар, 10.5 хувь нь 11-15 хувиар, 15.8 хувь нь 16-аас дээш хувиар үнээ өсгөсөн, 26.3 хувь нь үнээ өөрчлөөгүй бол 10.5 хувь нь 6-аас дээш хувь, 5.3 хувь нь 5 хүртэл хувиар тус тус буулгасан байна. Харин бараа бүтээгдэхүүн үйлчилгээгээ дотооддоо үйлдвэрлэхээс гадна гадаадаас импортолдог байгууллагуудын хувьд 30 хувь нь үнээ өөрчлөөгүй бол 30 хувь нь үнээ 6-10 хувь өсгөсөн байна.

Танай компани бараа бүтээгдэхүүн/үйлчилгээнийхээ үнийг ирэх 6 сард хир өөрчлөх вэ гэсэн асуултанд аж ахуйн нэгж, байгууллагуудын 22.3 хувь нь өсгөнө, 35.1 хувь нь өөрчлөхгүй, 5.6 хувь нь буулгана, 35.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн/үйлчилгээний үнийн өсөлт өмнөх санал асуулгатай харьцуулахад өсгөнө гэдэг хариулт 3.7 хувиар өсч, бууруулна гэсэн хариулт 0.3 хувиар буурсан байна.

Харин танай компанийн түүхий эд болон бусад бараа материал/үйлчилгээнд төлж байгаа үнэ ирэх 12 сард хэрхэн өөрчлөгдөнө гэж үзэж байна вэ гэхэд санал асуулганд оролцогсдын 25.4 хувь нь их өссөн, 31.8 хувь нь дунд зэрэг өссөн, 22.8 хувь нь бага зэрэг өссөн, 13.3 хувь нь хэвэндээ байсан, 3.6 хувь нь буурсан, 3.1 хувь хариулаагүй байна. Эхний улиралд явуулсан санал асуулгатай харьцуулахад их өссөн гэсэн хариулт 2.4 хувь, дунд зэрэг өссөн гэсэн хариулт 4.4 хувиар буурч, бага зэрэг өссөн гэсэн хариулт 4.2 хувиар өсч, буурсан гэсэн хариулт 0.5 хувиар буурсан байна.

Санал асуулгад оролцогсдоос ирэх 12 сарын хугацаанд бусад бараа материал/үйлчилгээний үнэд төлөх үнэ хэдэн хувиар өсөх вэ гэсэн асуултанд 36.2 хувь нь 5 хүртэл хувиар, 27.4 хувь нь 6-10 хувиар, 9 хувь нь 11-15 хувиар, 7.2 хувь нь 16-20 хувиар, 3.6 хувь нь 21-ээс дээш хувиар өснө гэсэн бол 1.3 хувь нь тодорхой мэдэхгүй байна гэж хариулсан байна. Эндээс харахад инфляцийн хүлээлтийг тоон утгаар асуухад аж ахуйн нэгж, байгууллагуудын 30 гаруй хувь нь үнийн өсөлтийг нам дор буюу 5 хүртэл хувиар, 30 орчим хувь нь түүнээс дээш хувиар өснө, үлдсэн хувь нь тодорхой хүлээлтгүй байна гэж гарч байна. Уг дүнг өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад 5 хүртэл

хувиар өснө гэсэн хариулт 16.8 хувиар, 6-10 хувиар өснө гэсэн хариулт 0.7 хувиар, 11-15 хувиар өснө гэсэн хариулт 11.2 хувиар, 16-20 хувиар өснө гэсэн хариулт мөн 11.2 хувиар, 21-ээс дээш хувиар өснө гэсэн хариулт 4.8 хувиар тус тус буурсан байгаа нь санал асуулга явуулах үеийн инфляцийн түвшинтэй холбоотой байна.

Харин инфляцийн хүлээлтийг чанарын асуултаар авч тоон утгыг хэвийн тархалтын аргаар Tomasz Lyziak-ийн зөвлөсний дагуу тооцоолоход жилийн инфляцийн хүлээлт **-3.2** хувь, харин цэвэр инфляциар тооцоолоход **1.07** хувь байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ямар асуудал илүү хүндрэл учруулж байгааг асуухад санал асуулганд оролцогсдын 22.1 хувь нь ажилчдын цалин хөлс, 21.3 хувь нь мэргэжлийн ажиллах хүч олох асуудал, 25.6 хувь нь зээлийн олдоц, 10.3 хувь нь зээлийн үнэ, 6.7 хувь нь түүхий эдийн олдоц, 29.2 хувь нь түүхий эдийн үнэ гэж хариулсан байна. Харин оны I улиралд явуулсан санал асуулгаар ажилчдын цалин хөлсний асуудал 9 хувиар, мэргэжлийн ажиллах хүчний асуудал 2.7 хувиар, зээлийн олдоц 4 хувиар, зээлийн үнэ 2.5 хувиар, түүхий эдийн олдоц асуудал үүсгэж байна гэсэн хариулт 2.2 хувиар багасч, түүхий эдийн үнийн асуудал 7 хувиар нэмэгдсэн байна. Эндээс харахад аж ахуйн нэгжүүдэд оны эхний улиралтай харьцуулахад ажилчдын цалин хөлснөөс учирч буй асуудал багасч, харин түүхий эдэнд төлөх үнэ илүү хүндрэл учруулах болсон байна.

Монгол Улсын эдийн засгийн талаар дүгнэлт өгөхийг хүсэхэд санал асуулганд оролцогсдын 2.1 хувь нь сайн, 56.4 хувь нь тааруухан, 35.4 хувь нь муу, 5.4 хувь нь мэдэхгүй, 0.8 хувь нь хариулт өгөөгүй байна. Энэ нь оны эхний санал асуулгатай харьцуулахад сайн гэсэн хариулт 1.7 хувиар муу гэсэн хариулт 8.2 хувиар, мэдэхгүй гэсэн хариулт 1 хувиар буурч, тааруухан гэсэн хариулт 10.1 хувиар өссөн байгаа аж ахуйн нэгжүүдийн дүгнэлт ялимгүй сайжирсан ч тааруухан хэвээр байгааг харуулж байна.

Хүснэгт 30. Та Монгол Улсын эдийн засгийн одоогийн байдалд ямар үнэлгээ өгөх вэ?

		Сайн	Тааруухан	Муу	Мэдэхгүй	Хариулаагүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	3.5%	46.7%	43.2%	6.6%	0%
	2009.III	2.2%	56.0%	36.7%	4.2%	0.8%
	Өөрчлөлт	-1.3	9.3	-6.5	-2.4	0.8
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	0%	43.5%	52.2%	4.3%	0%
	2009.III	0%	38.5%	23.1%	38.5%	0%
	Өөрчлөлт	0	-5	-29.1	34.2	0
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	7.7%	44.2%	42.3%	5.8%	0%
	2009.III	0%	75.0%	20.0%	5.0%	0%
	Өөрчлөлт	-7.7	30.8	-22.3	-0.8	0
Бүгд	2009.I	3.8%	46.2%	43.6%	6.4%	0%
	2009.III	2.1%	56.4%	35.4%	5.4%	0.8%
	Өөрчлөлт	-1.7	10.2	-8.2	-1	0.8

Санал асуулганд оролцогсдыг үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр нь ангилан Монгол Улсын эдийн засгийн байдалд хэрхэн дүгнэлт өгч байгааг нь гаргавал дотооддоо бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын 57 хувь нь тааруухан, 35.7 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн бол бараа бүтээгдэхүүнээ импортлодог байгууллагуудын 63.2 хувь нь тааруухан, 26.3 хувь нь муу, харин бараа бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэхээс гадна гаднаас импортлодог байгууллагуудын 48.8 хувь нь тааруухан, 37.2 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

Монгол Улсын эдийн засгийн байдал ирэх 6 сард хэрхэн өөрчлөгдөх вэ гэж асуухад санал асуулганд оролцогсдын 21.8 хувь нь сайжирна, 29.5 хувь нь өөрчлөгдөхгүй, 19.5 хувь нь дордоно, 27.9 хувь нь үнэлгээ өгч чадахгүй гэж хариулсан байна. Энэ нь оны эхний улирлын санал асуулгатай харьцуулахад сайжирна гэсэн хариулт 9.3 хувиар, өөрчлөгдөхгүй гэсэн хариулт 6.5 хувиар өсч, муудна гэсэн хариулт 14.2 хувиар буурч, үнэлгээ өгч чадахгүй гэсэн хариулт 4.9 хувиар буурсан байгаа нь аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн ирээдүйн байдалд итгэх итгэл нэмэгдэж байгааг харуулж байна. Түүнчлэн дээрх дүгнэлт нь аж ахуйн нэгж байгууллагуудын эдийн засгийн өнөөгийн байдалд өгч буй үнэлгээнээс дээгүүр байгаа нь эдийн засаг сайжрана гэсэн хүлээлт байгааг илтгэж байна.

Харин бизнесийн орчины тухайд бол санал асуулгад оролцогсдын 5.1 хувь нь тааламжтай, 36.4 хувь нь дунд зэрэг, 52.3 хувь нь тааламжтай бус, 5.9 хувь нь үнэлж мэдэхгүй байна гэсэн байгаа өмнөх санал асуулгатай харьцуулахад тааламжтай гэсэн хариулт 0.8 хувиар, үнэлж мэдэхгүй гэсэн хариулт 3.8 хувиар буурч, тааламжтай бус гэсэн хариулт 2.3 хувиар, дунд зэрэг гэсэн хариулт 2 хувиар өссөн байна.

Хүснэгт 31. Бизнесийн орчин Монголд ямар байна гэж үзэж байна вэ?

		Тааламжгүй	Дунд зэрэг	Тааламжтай бус	Үнэлж мэдэхгүй	Хариулаагүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг	2009.I	6.4%	35.9%	48.3%	9.4%	0%
	2009.III	5.5%	35.4%	52.7%	6.1%	0.3%
	Өөрчлөлт	-0.9	-0.5	4.4	-3.3	0.3
Импортлодог	2009.I	2.7%	21.6%	64.9%	10.8%	0%
	2009.III	5.3%	57.9%	31.6%	5.3%	0%
	Өөрчлөлт	2.6	36.3	-33.3	-5.5	0
Аль аль нь	2009.I	5.3%	35.1%	49.1%	10.5%	0%
	2009.III	2.3%	34.9%	58.1%	4.7%	0%
	Өөрчлөлт	-3	-0.2	9.0	-5.8	0
Бүгд	2009.I	5.9%	34.4%	50.0%	9.7%	0%
	2009.III	5.1%	36.4%	52.3%	5.9%	0.3%
	Өөрчлөлт	-0.8	2	2.3	-3.8	0.3

Үүнд дотооддоо үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг болон импортолдог, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл/ үйлчилгээгээ дотооддоо үзүүлэхээс гадна импортолдог гэх бүх л аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд бизнесийн орчинд өгөх үнэлгээ адил төстэй байна.

Хүснэгт 32. Бизнесийн орчин Монголд ямар байна гэж үзэж байна вэ?

		Тааламжгүй	Дунд зэрэг	Тааламжтай бус	Үнэлж мэдэхгүй	Хариу-лаагүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2009.I	6.0%	34.7%	51.1%	8.2%	0%
	2009.III	5.0%	35.3%	53.5%	5.9%	0.3%
	Өөрчлөлт	-1	0.6	2.4	-2.3	0.3
Гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	0%	26.1%	47.8%	26.1%	0%
	2009.III	7.7%	69.2%	23.1%	0%	0%
	Өөрчлөлт	7.7	43.1	-24.7	-26.1	0
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2009.I	7.7%	36.5%	44.2%	11.5%	0%
	2009.III	5.0%	35.0%	50.0%	10.0%	0%
	Өөрчлөлт	-2.7	-1.5	5.8	-1.5	0
Бүгд	2009.I	5.9%	34.4%	50.0%	9.7%	0%
	2009.III	5.1%	36.4%	52.3%	5.9%	0.3%
	Өөрчлөлт	-0.8	2	2.3	-3.8	0.3

Харин өмчийн хэлбэрийн хувьд дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын 35.3 хувь нь бизнесийн орчинд дунд зэрэг, 53.5 хувь нь тааруухан гэж үнэлгээ өгсөн байгаа нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 69.2 хувь нь дунд зэрэг, 23.1 хувь нь тааламжтай бус гэж хариулсан байгаатай харьцуулахад дотоодын болон дотоод, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниудын хувьд бизнесийн орчин илүү тааруу байгааг харуулж байна. Дээрх асуултын хариулт оны эхний улирлын санал асуулгын дүнтэй харьцуулахад тааламжтай бус гэсэн хариултын дүн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд буурч, дунд зэрэг болон тааламжтай гэсэн үнэлэлтийн дүн нэмэгдсэн ажиглагдаж байна.

Аж ахуйн нэгжүүдийн санал асуулгын дүнгээр бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд буурсан, үүнтэй холбоотойгоор эрэлтийн хүлээлт ирэх 6 сарын хугацаанд саармаг байгаа хэдий ч аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн/үйлчилгээний ирээдүйн үнийн шийдвэр бага өсөлтийг харуулж байгаа нь ирээдүйн инфляцийн хүлээлт бага дүнтэй байгаатай холбоотой байна. Санал асуулгаар Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал, бизнесийн орчинд өгөх дүгнэлт тааруухан байгаа хэдий ч ирэх 6 сарын хугацаанд байдал сайжирна гэсэн хүлээлт байгаа нь эерэг дохио юм. Санал асуулгад оролцогсдын 30 орчим хувь нь ирэх 6 сарын хугацаанд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх төлөвлөж байгаа, ажилчдынхаа тоог 20 орчим хувиар нэмэхийн зэрэгцээ 10 хүртэл хувиар цалингаа нэмэх бодолтой байгаа нь эдийн засагт ирэх 6 сард зарим таатай үзүүлэлтүүд гарах төлөвтэй байгааг харуулж байна.

Харин хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй аж ахуйн нэгжүүдийн 15 орчим хувь нь банкны зээлээр санхүүжүүлэлт хийх сонирхолтой байгаа боловч санал асуулгад оролцогсдын 50 гаруй хувь нь зээлийн олдоц 2009 онд буурсан гэж үзэж байгаа нь өнгөрсөн хугацаанд өндөр өсөлттэй байсан инфляцийг бууруулахаар авсан хатуу мөнгөний бодлогоор мөнгө нийлүүлэлт буурсантай холбоотой байна. Гэсэн хэдий ч Монголбанк 2009 оны 9 дүгээр сараас мөнгөний бодлогын хүүг бууруулж эхэлснээр аж ахуйн нэгжүүдэд очих зээлийн хэмжээ нэмэгдэх болно.

5. Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүн

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн (ШИХ) талаарх санал асуулгыг 2009 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс 15-ны өдөр хүртэлх хугацаанд явуулсан бөгөөд судалгаанд нийт арилжааны банкууд болон эдийн засгийн салбарт туршлага бүхий 11 шинжээчид оролцов. Шинжээчидтэй утсаар холбогдож, имэйл-ээр санал асуулгын хуудсаа явуулан бөглүүлэх замаар судалгааг авсан.

Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (ТБҮЦ-ны хүү, инфляци, M1, M2 мөнгөний өсөлт, төгрөгийн ханш)–ийг багтаасан бөгөөд улирал болон жилээр ангилан санал асуулгыг боловсруулсан. Шинжээчдээс авах санал асуулгын асуулт бүрийн хариултыг шууд тоон үзүүлэлтээр авсан бөгөөд шинжээчдийн таамагласан тоон үзүүлэлтүүдийн жигнэсэн дунджийг тооцох замаар ШИХ-ийг тооцоолов.


5.1. Улирлын таамаг

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн улирлын өөрчлөлтийн талаар шинжээчид дараах хүлээлттэй байна.

Инфляци

Шинжээчид Улаанбаатар хотын улирлын инфляци болон цэвэр инфляцийн түвшинг 2009 оны 3-р улирлаас 2010 оны 2-р улирал хүртэл хэрхэн таамагласныг зураг 2-т харуулав. Шинжээчид 2009 оны 3-р улирлын инфляцийн түвшинг 1.1 хувь болж өмнөх улирлаас 1.3 нэгжээр буурах бөгөөд 4-р улиралд 1.5 хувь болж өмнөх улирлаас 0.4 нэгжээр өсөхөөр таамаглажээ. Өмнөх судалгаатай харьцуулбал 3-р улирлын инфляцийн хүлээлт 2.7 нэгжээр буурсан бол 4-р улирлынх 5.5 нэгжээр өссөн байна. ҮСХ-ны гаргасан мэдээгээр 2009 оны 3-р улирлын инфляци -2.5 хувь байгаа нь шинжээчдийн хүлээлтээс 3.6 нэгжээр бага гарчээ. Харин 2010 оны 1-р улиралд инфляцийн түвшин 5.4 хувь, 2-р улиралд 6.4 хувь болж өснө гэсэн хүлээлттэй байна. Шинжээчдийн хүлээлтийг Монголбанкны тооцоолсон таамаглалтай харьцуулахад өөрчлөгдөх хандлага нь ижил боловч хэмжээ нь өөр байна. 2009 оны 4-р улирлын инфляци 2.4 нэгж, 2010 оны 1-р улирлын инфляци 1.8 нэгжээр өндөр, харин 2-р улирлынх адил түвшинд таамаглагдаж байна.

Зураг 2. Улирлын инфляцийн хүлээлт



Шатахуун, хүнсний бүтээгдэхүүнийг хасч тооцсон цэвэр инфляцийн түвшин 2009 оны 3-р улиралд 4.0 хувь болж өмнөх улирлаас 2.8 нэгжээр өсч, 4-р улиралд 0.4 хувь болж өмнөх улирлаас 3.6 нэгжээр буурна гэж шинжээчид таамагласан нь өмнөх судалгаатай харьцуулахад 3-р улирлын цэвэр инфляци 3.0 нэгжээр өссөн, 4-р улирлынх 0.3 нэгжээр буурсан хүлээлттэй байна. Цаашид цэвэр инфляцийн түвшин өсч 2010 оны 1-р улиралд 4.1 хувь, 2-р улиралд 4.7 хувь болохоор хүлээгдэж байна. Харин Монголбанкны тооцооллоор 2009 оны 3-р улирлын цэвэр инфляци 1.3 хувь гарсан нь шинжээчдийн хүлээлтээс 2.7 нэгжээр бага байгаа бөгөөд 4-р улирлын цэвэр инфляци 1.4 нэгж, 2010 оны 1-р улирлын цэвэр инфляци 3.0 нэгж ба 2-р улирлынх 1.5 нэгжээр тус тус өндөр байхаар таамаглажээ.

Шинжээчдийн таамагласан Улаанбаатар хотын улирлын инфляци болон цэвэр инфляцийн түвшинг харьцуулж үзвэл 2009 оны 3-р улиралд инфляцийн түвшин суурь инфляцийн түвшингээс 0.5 нэгжээр бага байхаар хүлээгдэж байсан бол 4-р улиралд 1.7 нэгж, 2010 оны 1-р улиралд 4.1 нэгж, 2-р улиралд 4.7 нэгжээр тус тус өндөр байгаагаас харвал шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнэ цаашид өсөхөөр хүлээгдэж байна.


2009 онд инфляцийн хүлээлт буурсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш харьцангуй тогтворжиж, эдийн засгийн уналтыг даган өрхийн хэрэглээ нэмэгдэхгүй байгаа шалтгаанаар тайлбарлаж болох юм. Харин 2010 оноос уул уурхайн салбарын өсөлтийг дагасан төсвийн тэлэлт, дэлхийн зах зээл дээрх шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт зэргээс хамаарч инфляци эргээд өсөх хандлагатай болж болзошгүй байна.

Бодлогын хүү (суурь хүү)

Бодлогын хүүг шинжээчид хэрхэн таамагласныг зураг 3-т харуулав. Шинжээчдийн таамгаар 2009 оны 3-р улирлын эцэст бодлогын хүү өмнөх улирлаас 0.8 нэгжээр буурч 10.7 хувь болохоор таамагласан бол 3-р улирлын эцэст 10.0 хувь болсон байв. Харин 2009 оны 4-р улирлын эцэст өмнөх улирлаас бага зэрэг буурч 10.4 хувь, 2010 оны 1-р улирлын

эцэст 10.0 хувь, 2010 оны 2-р улирлын эцэст 9.8 хувь болохоор хүлээгдэж байна. Шинжээчдийн таамгаас харахад бодлогын хүүг цаашид тогтмол буурахаар төсөөлж байгаа бөгөөд өмнөх судалгаатай харьцуулахад 2009 оны 3-р улирлын төсөөлөл 2.5 нэгж, 4-р улирлынх 1.9 нэгжээр тус тус буурчээ.

Зураг 3. Бодлогын хүү, шинжээчдийн таамгаар



Инфляци буурч, ханш тогтворжиж байгаа учраас эдийн засгийг сэргээх зорилгоор Монголбанк бодлогын хүүг цаашид аажим бууруулна гэж шинжээчид төсөөлж байна.


Мөнгөний агрегатууд

Шинжээчид $M1^{13}$ болон $M2^{14}$ мөнгөний улирлын өсөлтийг хэрхэн таамагласныг зураг 4-т харуулав. Шинжээчдийн таамгаар 2009 оны 3-р улирлаас 2010 оны 1-р улирал хүртэл $M1$ мөнгөний өсөлт буурах хандлагатай байх бөгөөд 2009 оны 3-р улиралд өмнөх улирлаас 1.3 нэгжээр буурч 5.2 хувь, 4-р улиралд 4.2 хувь, 2010 оны 1-р улиралд 3.1 хувь болж тус тус буураад, 2-р улиралд өмнөх улирлаас 1.3 нэгжээр нэмэгдэж 4.4 хувийн өсөлттэй байна гэж тооцоолж байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулахад 3-р улирлын $M1$ мөнгөний өсөлт 1.6 нэгж, 4-р улирлынх 2.9 нэгжээр тус тус буурсан дүн юм. Харин ҮСХ-ны мэдээгээр $M1$ мөнгөний өсөлт 2009 оны 3-р улиралд 14.4 хувь гарсан нь шинжээчдийн таамгаас 9.2 нэгжээр их гарчээ. Шинжээчдийн таамгийг Монголбанкны тооцоолж буй таамагтай харьцуулахад 4-р улирлын өсөлт 9.7 нэгжээр өндөр байгаа бол 2010 оны 1-р улирлынх 2.9 нэгж, 2-р улирлынх 10.6 нэгжээр тус тус бага байна.

¹³ $M1$ мөнгө- банкнаас гадуурхи мөнгө, иргэд байгууллагын төгрөгийн харилцах данс

¹⁴ $M2$ мөнгө- $M1$ мөнгө ба бараг мөнгөний нийлбэр

Зураг 4. М1 ба М2 мөнгөний өсөлт, шинжээчдийн таамгаар



Шинжээчид М2 мөнгөний өсөлт 2009 оны 3-р улиралд өмнөх улирлаас 4.6 нэгжээр нэмэгдэж 0.9 хувь болно гэж таамаглаж байсан бол ҮСХ-ны мэдээгээр М2 мөнгөний өсөлт 2009 оны 3-р улирлын байдлаар 8.8 хувь гарчээ. Шинжээчдийн таамгаар М2 мөнгөний өсөлт цаашид нэмэгдэнэ гэж үзэж байгаа бөгөөд 4-р улирлын эцэст өмнөх улирлаас 0.2 нэгжээр өсч 1.1 хувь болохоор тооцоолжээ. Мөн 2010 оны 1-р улирлын эцэст 1.9 хувь, 2-р улирлын эцэст 3.6 хувьд хүрч тус тус өснө гэж таамагласан байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4 улирлын М2 мөнгөний өсөлтийн таамаг харгалзан 1.7 ба 0.1 нэгжээр өссөн боловч Монголбанкны тооцоолсон таамаглалтай харьцуулахад эрс бага буюу 4-р улиралд 5.3 нэгж, 2010 оны 1-р улиралд 6.2 нэгж ба 2-р улиралд 11.3 нэгжээр тус тус бага байна.


М1 мөнгөний өсөлт 2010 оны 1-р улирал хүртэл буурах хандлагатай боловч М2 мөнгөний өсөлт нэмэгдэж байгаагаас харвал хадгаламжийн хэмжээг илүү өснө гэж шинжээчид таамаглаж байна. Монголбанк бодлогын хүүгээ бууруулж, зээл олголтыг нэмэгдүүлснээр мөнгөний нийлүүлэлт өсөх боломжтой гэж үзэж байгаатай холбоотойгоор шинжээчид М2 мөнгөний өсөлт нэмэгдэнэ гэж таамагласан болов уу.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханши

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг шинжээчид хэрхэн таамагласныг зураг 5-д харуулав. Шинжээчид 2009 оны 3-р улирлын эцэст төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш өмнөх улирлаас 1.3 хувиар буурч 1409.4 төгрөг, 4-р улирлын эцэст өмнөх улирлаас 0.6 хувиар буурч 1400.6 төгрөгт хүрэхээр таамагласан нь өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын төгрөгийн ханш тус бүр 0.1 хувиар чангарсан байна. 2009 оны 3-р улирлын эцэст төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1418.5 төгрөг болсон нь шинжээчдийн хүлээлтээс 9.1 төгрөг буюу 0.6 хувиар өндөр гарчээ. Цаашид төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш цаашид тогтмол буурч 2010 оны 1 ба 2-р улирлын эцэст харгалзан 1391 ба 1374.4 төгрөг болно гэж шинжээчид тооцоолсон нь

Монголбанкны таамаглаж буй ханшаас илүү чангарах төлөвтэй буюу 4-р улиралд 0.2 хувь, 2010 оны 1-р улиралд 0.4 хувь ба 2-р улиралд 0.004 хувиар өндөр байна.

Зураг 5. Төгрөг/долларын ба төгрөг/юаны нэрлэсэн ханш, шинжээчдийн таамгаар




Шинжээчдийн таамаглаж буйгаар төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 2009 оны 3 ба 4-р улиралд харгалзан 207.3 ба 206.6 төгрөг болж буураад 2010 оны 1-р улиралд 208.6 төгрөг хүрч бага зэрэг өсөхөөр байна. Харин 2010 оны 2-р улиралд 206.5 төгрөг болж өмнөх улирлаас 1.0 хувиар буурна гэж тооцоолжээ. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 2009 оны 3-р улирлын эцсийн байдлаар 208.9 төгрөг болсон нь шинжээчдийн таамгаас 1.6 төгрөг буюу 0.1 хувиар их гарчээ. Шинжээчдийн таамгаас харахад төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханшийн талаарх хүлээлт өмнөх судалгааны дүнтэй харьцангуй төстэй байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2009 оны 2-р улирлаас буурч, тогтворжсон нь зах зээл дээрх ханшийн хүлээлтийг бууруулж байна. Мөн Оюу толгой зэрэг томоохон уул уурхайн ордуудыг ашигласнаар хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэхээр байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чангаруулж болзошгүй юм.

Топ-20 индекс

Шинжээчид Топ-20 индексийг хэрхэн таамагласныг зураг 6-д харуулав. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй шилдэг 20 компанийг оруулан тооцдог Топ-20 индекс шинжээчдийн таамаглаж буйгаар 2009 оны 3-р улирлын эцэст 5364.0 болж өмнөх улирлаас 9.8 хувиар өсөх бөгөөд 2009 оны 4-р улиралд 5551.4, 2010 оны 1-р улирлын эцэст 5865.1, 2-р улирлын эцэст 6195.5 болж цаашид өсөлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын таамаг тус тус 0.1 нэгжээр өсчээ. Харин хөрөнгийн биржийн мэдээгээр Топ-20 индекс 2009 оны 3-р улирлын эцсийн байдлаар 6890.8 болсон нь шинжээчдийн хүлээлтээс 1526.8 буюу 28.5 хувиар их гарсан байна.

Зураг 6. Топ-20 индекс, шинжээчдийн таамгаар



Шинжээчдийн улирлын таамгаас харахад инфляци, цэвэр инфляци, M2 мөнгөний өсөлт ба топ-20 индекс өсөх хандлагатай бол M1 мөнгөний өсөлт, ТБҮЦ-ны хүү болон төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийг тогтмол буурахаар төсөөлж байна.


5.2. Жилийн таамаг

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн ирэх хоёр жилийн хугацаанд гарах өөрчлөлтийн талаар шинжээчид дараах хүлээлттэй байна.

Инфляци

ҮСХ-ны мэдээгээр жилийн инфляци 2008 оны эцэст 22.1 хувь байсан бөгөөд шинжээчдийн таамгаар 2009 оны эцэст өмнөх оныхоос 12.2 нэгжээр буурч 8.9 хувь болно гэсэн хүлээлттэй байна. Энэ нь “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-д жилийн инфляцийг нэг оронтой тоонд байлгана гэсэн зорилтот түвшинтэй нийцэж байна. Харин 2010 оны эцэст жилийн инфляцийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.1 нэгжээр өсч 10.0 хувь болно гэж таамаглажээ. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-д жилийн инфляцийг 8 хувь байлгах зорилт тавьсан бөгөөд шинжээчдийн таамаг уг зорилтот түвшингээс 2 хувиар их байна.

Зураг 7. Жилийн инфляцийн хүлээлт




Шинжээчдийн таамгаар 2009 оны инфляцийн түвшин ОУВС-ийн тооцоолж буй таамаглалтай төстэй байгаа бол 2010 оных Монголбанкны тооцоолсон таамаглалтай ойролцоо байна. Харин цэвэр инфляци 2008 оны эцэст 19.1 хувь байсан бол 2009 оны эцэст 12.9 хувь, 2010 оны эцэст 12.3 хувь болж тус тус буурна гэсэн хүлээлттэй байгаа нь Монголбанкны тооцоолж буй түвшингээс харьцангуй өндөр байна.

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2009 оны жилийн инфляцийн түвшин 10.8 нэгжээр, 2010 оных 6.4 нэгжээр, харин цэвэр инфляци харгалзан 5.9 ба 4.9 нэгжээр тус тус буурсан байна. 2008 оны дунд үеэс хурдацтай өсч эхэлсэн үнийн өсөлтийн үр дагавар 2009 оны 1-р улиралд (өмнөх судалгаа) шинжээчдэд өндөр инфляцийн хүлээлтийг бий болгож байсан бол 2009 оны 8 сарын байдлаар жилийн инфляцийн түвшин буурч, тогтворжин -0.9 хувь болсон нь тэдний ирээдүйн инфляцийн талаарх хүлээлтийг бууруулж байна. Харин өмнөх судалгаагаар 2010 оны жилийн инфляцийн түвшин 2009 оныхоосоо буурна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 2010 оны жилийн инфляцийн түвшин 2009 оныхтой харьцуулахад өснө гэж хүлээгдэж байна.

ДНБ-ний өсөлт

Шинжээчдийн таамгаар ДНБ-ний өсөлт 2009 онд огцом саарах төлөвтэй байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 5.3 нэгжээр буурч 3.6 хувь, харин 2010 онд өмнөх оноос 3.8 нэгжээр өсч 7.4 хувь болно гэж төсөөлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 2009 оны өсөлт 1.9 нэгж, 2010 оных 0.1 нэгжээр тус тус буурсан хүлээлттэй байна. Энэ нь Монголбанкны тооцсон таамаглалаас 2009 оны ДНБ-ний өсөлт 2.6 нэгжээр их бол 2010 оных 5.5 нэгжээр бага байна. Мөн ОУВС-аас Монгол улсын эдийн засгийн бодит өсөлтийн төсөөллийг 2009 онд 0.5 хувь, 2010 онд 3.0 хувь болохоор тооцсон нь шинжээчдийн хүлээлтээс харьцангуй бага байна.

Зураг 8. ДНБ-ний өсөлтийн таамаг




Эдийн засгийн хямралын үед экспортын барааны үнийн уналт, ЗГ-ын зардлын бууралт болон мөнгөний хатуу бодлоготой холбоотойгоор 2009 онд ДНБ огцом буурахаар хүлээгдэж байгаа ч Монголбанк болон ОУВС-ийн төсөөллөөс шинжээчдийнх өндөр байна. Харин 2010 онд дэлхийн эдийн засаг сэргэж эхлэх төлөвтэй байгаа бөгөөд хоёр том уул уурхайн төслийн урьдчилгаа төлбөр, түүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, ажил эрхлэлт нэмэгдэх боломжтой байгаа нь 2010 оны ДНБ-ийг өснө гэсэн таамаглалд хүргэж болох юм.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт

M2 мөнгөний жилийн өсөлт 2008 онд -2.5 хувь байсан бөгөөд шинжээчдийн таамаглалаар 2009 онд өмнөх оныхоос 4.4 нэгжээр өсч 1.9 хувь, 2010 онд өмнөх оныхоос 3.1 нэгжээр өсч 7.5 хувь болно гэж тооцоолсон нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2009 оны таамаг 2.3 нэгж, 2010 оных 3.7 нэгжээр тус тус өсчээ. Гэсэн ч шинжээчдийн таамаг Монголбанкны тооцож буй төсөөллөөс эрс бага буюу 2009 оных 8.1 нэгж, 2010 оных 16.5 нэгжээр тус тус бага байна.

Зураг 9. M2 мөнгөний жилийн өсөлтийн таамаг




Инфляци буурч, төгрөгийн ханш тогтворжсон учраас бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд Монголбанк бодлогын хүүгээ бууруулж, зээл олголтыг нэмэгдүүлснээр мөнгөний нийлүүлэлт өсөх боломжтой гэж үзэж байгаатай холбоотойгоор шинжээчид M2 мөнгөний өсөлт нэмэгдэнэ гэж таамагласан болов уу.

Гадаад худалдаа

Шинжээчдийн үзэж байгаагаар нийт экспортын хэмжээ 2009 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.4 хувиар буурч 2325.6 сая ам.доллар, нийт импортын хэмжээ 16.0 хувиар буурч 3038.7 сая ам.доллар болно гэж тооцоолж байна. Харин 2010 онд өмнөх оныхтой харьцуулахад нийт экспорт 29.4 хувиар өсч 3010.3 сая ам.доллар, нийт импорт 20.1 хувиар өсч 3650.7 сая ам.долларт хүрнэ гэж таамаглажээ. Уг таамгийг өмнөх судалгаатай харьцуулахад нийт экспорт 2009 онд 0.1 нэгж, нийт импорт 0.2 нэгжээр буурсан бол 2010 онд нийт экспорт 0.3 нэгж, нийт импорт 0.2 нэгжээр тус тус өссөн байна. Энэ нь Монголбанкны тооцоолж буй төсөөллөөс 2009 онд нийт экспортын хэмжээ 0.4 хувь, нийт импортын хэмжээ 0.7 хувь, 2010 онд нийт экспот 0.6 хувь, нийт импорт 0.5 хувиар тус тус их байхаар хүлээгдэж байна.

Зураг 10. Нийт экспорт ба нийт импортын таамаг




Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ 8-р сарын турш тогтвортой өсөлттэй байсан бөгөөд Монгол улсын худалдааны гол түншүүдийн эдийн засаг сэргэж эхэлж байгаа нь манай улсын нийт экспортыг өсгөх боломжтой юм. Мөн импортын голлох бүтээгдэхүүн болох шатахуун, зарим хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх хандалагатай байгаа нь нийт импортыг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Гэхдээ шинжээчдийн таамгаар нийт экспорт болон нийт импорт хоёулаа өсөх боловч экспортын өсөлт импортынхоос давсан байгаагаас гадаад худалдааны алдагдал багасахаар төсөөлж байна.

Дундаж цалин

ҮСХ-ны мэдээгээр аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин 2008 оны эцэст 272.4 мянган төгрөгт хүрч өмнөх оныхоос 57.5 хувиар өсчээ. Харин шинжээчдийн хүлээлтээр дундаж цалин 2009 онд өмнөх оныхтой харьцуулахад 5.5 хувиар өсч 287.4 мянган төгрөг, 2010 онд 2009 оныхтой харьцуулахад 12.9 хувиар өсч 324.4 мянган төгрөгт хүрнэ гэж үзэж байна. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс 2009 оны дундаж цалин 0.03 хувиар, 2010 оных 0.05 хувиар тус тус өссөн дүн юм. Харин Монголбанкны тооцсон төсөөлөлтэй харьцуулбал дундаж цалингийн өсөлт 2009 онд 4.2 нэгжээр их байгаа бол 2010 онд 3.0 нэгжээр бага хүлээлттэй байна.

Зураг 11. Дундаж цалингийн жилийн өсөлтийн таамаг



Дээрх таамгаас харахад дундаж цалин 2009 оныхоос 2010 онд харьцангуй их өсөхөөр хүлээгдэж байгаа нь 2010 оноос Оюу толгой төслийн урьдчилгаа төлбөр орж ирснээр төсөв тэлэх, мөн үнийн өсөлт зэрэгтэй холбоотой байж болох юм.

Шинжээчдийн жилийн таамгаас харахад 2009 онд инфляци, ДНБ-ний өсөлт, нийт экспорт ба нийт импортын хэмжээ буурч, М2 мөнгөний өсөлт болон дундаж цалин нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол 2010 онд эдгээр үзүүлэлтүүд бүгд өснө гэсэн хүлээлттэй байна.

Хүснэгт 33 ба 34-т 2009 оны 1-р улирлын шинжээчдийн хүлээлтийг 2009 оны 3-р улирлын байдлаарх хүлээлттэй харьцуулсан дүнг харуулав.

Хүснэгт 33. Улирлын таамаг

	2009: Q2	2009:Q3		2009:Q4		2010:Q1		2010:Q2	
		Хүл.І	Хүл.ІІ	Хүл.І	Хүл.ІІ	Хүл.І	Хүл.ІІ	Хүл.І	Хүл.ІІ
1. 1 долоо хоногтой ТБҮЦ-ны хүү	11,0	12,9	10,7	11,9	10,7	-	10,0	-	9,8
6. Инфляци (хувиар)	4,2	18,6	6,7	19,0	8,5	-	7,0	-	8,2
7. Суурь инфляци (хувиар)	1,0	18,1	5,0	18,8	5,4	-	4,1	-	4,7
8. М1 мөнгөний өсөлт (хувиар)	6,45	6,9	5,2	7,2	4,2	-	3,1	-	4,4
9. М2 мөнгөний өсөлт (хувиар)	-3,68	-0,8	0,9	1,0	1,1	-	1,9	-	3,6
10. Төгрөг/долларын ханш	1,428,56	1526,7	1409,4	1510,8	1400,6	-	1391,0	-	1374,4
11. Төгрөг/юаны ханш	210,08	207,4	207,3	209,0	206,6	-	208,6	-	206,5
12. TOP-20 Индекс	4884,18	5148,4	5469,0	5234,4	5551,4	-	5865,1	-	6195,5

Хүснэгт 34. Жилийн таамаг

	2008	2009		2010	
		Хүл.I	Хүл.II	Хүл.I	Хүл.II
1. Инфляци (жилийн өсөлт хувиар)	22.1	19,7	8,9	16,4	10,0
2. Суурь инфляци (жилийн өсөлт хувиар)	23.1	18,9	12,9	17,3	12,3
3. M2 мөнгө (жилийн өсөлт хувиар)	-2.5	-0,4	1,9	3,8	7,5
4. Нийт экспортын дүн /сая ам.доллараар/	2,539.3	2363,3	2325,6	2871,4	3010,3
5. Нийт импортын дүн /сая ам.доллараар/	3,615.8	2540,0	3038,7	3359,2	3650,7
6. Улсын дундаж сарын цалин /төгрөгөөр/	272,400	279350,0	287354,0	307142,0	324400,0
7. ДНБ-ий өсөлт (жилийн өсөлт хувиар)	8.9*	5,5	3,6	7,5	7,4

6. Дүгнэлт

Инфляцийн хүлээлтийн 2 дахь удаагийн санал асуулгыг 2009 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо явуулж дүгнэлээ. Санал асуулганд Улаанбаатар хотын 8 дүүргийн 1000 иргэн, Улаанбаатар хотод бүртгэлтэй 390 аж ахуйн нэгж, 11 шинжээчид оролцлоо. Иргэдийн санал асуулга нь Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүд болох Налайх, Багануур дүүргүүдийн иргэдийг оролцуулсан нь 2008 оны 12 сард явуулсан санал асуулгаас сайжирч илүү өргөн хүрээг хамарсан гэж хэлж болно.

Энэ удаагийн санал асуулга нь Улаанбаатар хотод дефляцитай үед явагдсанаараа онцлог байлаа. Иймээс инфляцийн хүлээлтийг өргөтгөсөн Carlson-Parkin –ны аргаар дефляцитай үед хэрхэн тооцоолох талаар Польшийн Төв Банкны мэргэжилтэн Tomasz Łyziak –аас зөвлөгөө авлаа. Ингээд иргэд, аж ахуйн нэгжүүдийн инфляцийн хүлээлтийг T.Łyziak –ийн зөвлөсний дагуу, мөн үнийн хэлбэлзэл ихтэй бараа бүтээгдэхүүнүүдийг хасаж тооцсон цэвэр инфляциар тус тус тооцож гаргасан.

Иргэдийн инфляцийн хүлээлт нь 2008 оны 12 дугаар сард 20.4 хувь байсан бол энэ удаагийн судалгаагаар T.Łyziak –ийн зөвлөсний дагуу тооцоолоход -1.84, цэвэр инфляциар 2.59 хувь болж тус тус буурсан байна. Харин ААНБ-уудынх өмнөх судалгаагаар 14.9 хувь гарсан бол энэ удаагийн судалгаагаар T.Łyziak –ийн зөвлөсний дагуу тооцоолоход -3.2, цэвэр инфляциар 1.07 хувь гарсан байна. Шинжээчдийн инфляцийн хүлээлтийг шууд тоон утгаар санал асуулга авч бөглүүлсэн бөгөөд 2009 оны эцэст 8.9 хувь, 2010 оны эцэст 10.0 хувь байх хүлээлттэй байна. Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэмжээ болон дэлхийн эдийн засгийн орчны нөлөөллийн дүнд инфляцийн түвшин 2009 оны эхний 9 сард огцом буурч эхэлсэн бөгөөд энэ нь иргэд аж ахуйн нэгжүүдийн инфляцийн хүлээлтийг бууруулахад хүргэсэн байна.

Инфляци хурдтай буурахын хэрээр эдийн засгийн өсөлт удааширч, зогсонги байдалд орж байгаа нь санал асуулгын үр дүнгээр харагдаж байна. Инфляцийн хүлээлтийн судалгааны аж ахуйн нэгж, байгууллагуудын санал асуулгад оролцсон 390 байгууллагуудын хувьд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнийх нь эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд буурсан, борлогдоогүй барааны үлдэгдэл их байгаа нь худалдан авалт буурсныг харуулж байна. Түүнчлэн санал асуулгад оролцогсод ирэх 6 сарын хугацаанд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх бодолгүй байгаагийн зэрэгцээ ажилчдынхаа тоог нэмэгдүүлэх, цалингаа нэмэх төлөв байдал ажиглагдсангүй. Мөн Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал болон бизнесийн орчинд тааруухан гэсэн үнэлэлт өгсөн бол ирэх 6 сард эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдөх вэ гэсэн асуултанд өөрчлөгдөхгүй эсвэл үнэлгээ өгч чадахгүй байна гэсэн хариулт өгсөн нь нийгэмд эдийн засгийн талаарх ирээдүйн хүлээлт тодорхойгүй, манай улсын стратегийн томоохон ач холбогдолтой орд газруудыг ашиглахтай холбогдуулан олон шийдвэрүүд гарч байгаатай холбоотой байна.

Шинжээчид жилийн инфляци 2009 оны эцэст өмнөх оны мөн үеэс 12.2 нэгжээр буурч 8.9 хувь болно гэсэн хүлээлттэй байна. Энэ нь төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд 2009 оны эцэст жилийн инфляцийг нэг оронтой тоонд байлгах зорилтот түвшинтэй нийцэж байна. 2010 оны эцэст инфляцийн түвшин өмнөх оны эцсээс 2.0 нэгжээр буурч 10.0 хувь болно гэж таамаглажээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд 2010 оны эцэст инфляцийг 8 хувь байлгах зорилт тавьсан бөгөөд шинжээчдийн таамаг уг зорилтот түвшингээс 2 нэгжээр их байна. Харин суурь инфляци 2008 оны эцэст 23.1 хувь байсан бөгөөд 2009 оны эцэст 12.9 хувь, 2010 оны эцэст 12.3 хувь болж буурна гэж тооцоолж байна.

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2009 оноос эхлэн жилд 2 удаа хэрэглэгчид, аж ахуйн нэгж байгууллагууд болон шинжээчид гэсэн ангиллаар явуулж байна. Цаашид уг судалгааг явуулах давтамжийг (улирлаар, сараар) олон болговол Монголбанкны мөнгөний бодлогын загварт ашиглаж болохуйц тоон өгөгдлийг гаргах бололцоотой болох юм.